MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,140.904... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.05.04. Пүрэв. №088 (4702) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЭГҮЙ БАЙХАД ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА НЬ ХҮНИЙ ЭРХИЙГ ЗӨРЧИЖ БАЙНА ГЭВ

II нүүрт

ДЭЛХИЙ

СОЛОНГОСЫГ УДИРДАХ МАГАДЛАЛТАЙ МҮН ЖЭ ИН ГЭЖ ХЭН БЭ

IV нүүрт

Дугаарын 60 мөр

## Сэтгүүлчид нохойд барьдаг мод биш

Г.ДОРЖ

"Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр"-ийг Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөр өөрийнхөөрөө тэмдэглэж өнгөрүүлэв, өчигдөр. Ач холбогдол өгсөн нь ч бий, өгөөгүй нь ч бий. Хэвлэл мэдээллийн аль байгууллагын цаана сэтгүүлчийн нөр их хөдөлмөр оршиж байдаг. Өглөөн нартай уралдаж ажилдаа явсан сэтгүүлч үдшийн бүрий тасрахтай уралдан гэрийн бараа хардаг. Сонин нь хэдэн цагт хэвлэх үйлдвэр рүү шилжинэ тэр цагт гэртээ харих эрх нь нээгддэг гэж хэлж болно. Өмнө ч тийм л байсан эдүгээ ч ялгаагүй. Хойшид ч тийм байх биз. Үйл явдал хаана өрнөнө тэр газарт сэтгүүлч л ажлаа хийж байдаг юм.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

# МАН-ААС М.ЭНХБОЛД ИЛҮҮРХЭЖ, АН НЭР ДЭВШИГЧЭЭ ТОДРУУЛЖ ЧАДСАНГҮЙ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ӨНӨРТОГТОХ

Сонгуулийн тухай хуульд зааснаар тавдугаар сарын эхний долоо хоногт буюу энэ сарын 7 гэхэд парламентад суудалтай улс төрийн намууд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчөө албан ёсоор тодруулж, СЕХ-д мэдэгдэх учиртай. Тэр ч ёсоор өчигдөр улс төрийн хоёр том хүчний нэг болох МАН наймдугаар Бага хурлаа Тусгаар тогтнолын ордонд хийж, нэр дэвшигчээ тодруулсан юм. Харин Ардчилсан намын хувьд өчигдөр намын дотоод сонгуулиар нэр дэвшигчээ тодруулж, улмаар энэ сарын 6-нд буюу ирэх бямба гарагт Төрийн ордонд Их хурлаа хийж, нэр дэвшигчээ баталгаажуулахаар байсан ч амжсангүй. Парламентад нэг л гишүүний суудал авсан МАХН-аас нэр дэвшигч өрсөлдөх эсэх нь тун сонирхолтой байгаа. МАХН ямар тоглолт хийхээс АН, МАН нэр дэвшигчдийн санал хуваагдах магадлал өндөр учраас Н.Энхбаярын намын нүүдэл иргэдийн сонирхлын зүй ёсоор татаж буй юм.

**Үргэлжлэл нь III нүүрт**





Forbes MONGOLIA
MONGOLIAN PROPERTY AWARDS

ЗАЛУУСЫН ХОТХОН
X Apartment
ШИЛДГЭЭР ТОДОРЛОО



Дэлхийн 15 оронд хэвлэгдэн гардаг, санхүүгийн №1 Forbes сэтгүүлээс жил бүр шалгаруулдаг **"MONGOLIAN PROPERTY AWARDS"**-ын 2016 оны Үл хөдлөхийн шилдэгээр **Залуусын хотхон "X Apartment"** тодорч **"Шилдэг орон сууц"** өргөмжлөлийг хүртэн, дэлхийн орон бүрт тодруулдаг энэхүү нэр хүндтэй шагналын эзэн боллоо.

Залуусын хотхон **"X APARTMENT"** нь хотын төвөөс 4км зайд, нийслэлийн А зэрэглэлийн бүсэд байрлалтай бөгөөд **Япон архитекторын орон зайн төгс шийдлээр**, өрөө бүрт нарны гэрэл бүрэн тусахаар маш нарийн тооцсон зохион байгуулалтын өвөрмөц төлөвлөлт, 24 цагийн хүлээн авах ресепшн, Монтессори сургалттай цэцэрлэг, таны хэрэгцээг бүрэн хангах бүх төрлийн үйлчилгээг нэг дор бүрдүүлсэнээрээ бусдаас онцлог давуу талтай юм.



Стандарт загвар: 1 өрөө
30 - 32 мкв



Стандарт загвар: 2 өрөө
54 - 64мкв



Стандарт загвар: 3 өрөө
59.5 - 82 мкв



Дуплекс загвар: 2-4 өрөө
37.5 - 104 мкв

ДЭЛХИЙД ЧАНАРААР ТЭРГҮҮЛЭГЧ ЯПОН БРЭНДҮҮДЭЭР "X APARTMENT"-ЫГ ТОНОГЛОЛОО

VEKA — ГЕРМАН ВАКУМ ЦОНХ
TOTO — ЯПОН САНГИЙН ТОНОГЛОЛ
LG Hausys — СОЛОНГОС ОБОЙ
NIPPON PAINT — ЯПОН БУДАГ, ЭМУЛЬС
EGGER — АВСТРИ ПАРКЕТАН ШАЛ
ThyssenKrupp — ГЕРМАН ЦАХИЛГААН ШАТ
AQUATHERM — ГЕРМАН ХОЛБОХ ХЭРЭГСЭЛ
MEGAWOOD — MEGAWOOD ХААЛГА

Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд "УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ" ХХК

77009919, 96066329, 88002312, 88030203
www.xapartment.mn


**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2410.00 | 2426.00 | ФУНТ | 3082.00 | 3161.00 |
| ЕВРО | 2606.00 | 2676.00 | РУБЛЬ | 41.50 | 43.60 |
| ИЕН | 21.43 | 21.74 | ЮАНЬ | 349.00 | 352.40 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2414.00 | 2426.00 | ФУНТ | 3093.00 | 3167.00 |
| ЕВРО | 2610.00 | 2676.00 | РУБЛЬ | 41.34 | 44.42 |
| ИЕН | 21.30 | 21.87 | ЮАНЬ | 349.00 | 351.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЭГҮЙ БАЙХАД ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА НЬ ХҮНИЙ ЭРХИЙГ ЗӨРЧИЖ БАЙНА ГЭВ

Б.ТОГТОХ


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ дахь АН-ын бүлгээс өчигдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслөөр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд, Хууль зүйн яамны төлөөлөл, хуульчид болоод хүний эрхийн ТББ-ын төлөөлөл, салбарын эрдэмтэд оролцов. Хэлэлцүүлгийн нээж, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат "Бид энэ хуулийг өргөн хүрээнд хэлэлцэж зөв шийдлүүдийг гаргах ёстой гэдэг байр суурьтай байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг хэлэлцэх гэж байгаатай холбоотойгоор мэргэжлийн судлаачдын болон Ардчилсан намын гишүүдийн зарчмын зөрүүтэй олон байр суурь илэрхийлэгдэж байгаа. Тиймээс ч энэ хэлэлцүүлгийг явуулах нь зүйтэй гэж үзсэн. Хэлэлцүүлэгт Ажлын хэсгийг удирдаж байгаа хүмүүс оролцож байгаа нь зөв. Аливаа хуулийг батлан гаргахдаа яг мэргэжлийн хүмүүсийн санал бодлыг заавал тусгаж байх ёстой. Эдгээр хуулиуд зөвхөн улс төрийн буюу олонхийн, цөөнхийн шийдлээр гарч болохгүй. Нийгмийн бүх давхаргыг хамарч байгаа. Тиймээс энэ асуудалд анхааралтай хандах ёстой юм. Хуучин Байцаан шийтгэх гэдэг нэртэй байсан хуулийг өөрчлөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль болгон шинээр оруулж ирж байгаа хууль. Шүүх хэлэлцээд, хэрэг ойлгомжгүй бол буцаагаад явуулдаг байдлыг болиулах, цагдан хорих байранд гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хориглох, иргэнд Эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө прокурорын зөвшөөрлөөр гүйцэтгэх ажиллагаа явуулах гэх мэтээр иргэний эрхтэй холбоотой олон заалтууд ойлгомжгүй байна. Тиймээс УИХ дахь Ардчилсан намын бүлгээс Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Л.Болд гишүүн томилогдон ажиллаж байна. Энэ хүрээнд Л.Болд гишүүн холбогдох салбарынхантай уулзаж, санал солилцсон. Гэхдээ энэ удаагийн хэлэлцүүлэгт олон талын төлөөлөл оролцож байгаа. Тиймээс хэлэлцүүлэг ач холдогдолтой, үр дүнтэй болно гэж найдаж байна. Ардчилсан намын бүлэгт болоод хуулийн ажлын хэсэгт ч боломж олгож, санаа өгөх байх гэж найдаж байна" гэсэн юм. Харин ажлын хэсгийн ахлагч Л.Болд "Хэлэлцүүлгийн эхэнд энэ өдрийг онцлох нь чухал байх. Учир нь өнөөдөр /өчигдөр/ "Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр" тохиож байгаа.

Миний хувьд 1990 оны өөрчлөлтийн хамгийн том ололт бол үгээ хэлэх хэвлэлийн эрх чөлөө гэж үздэг. Энэ эрх чөлөө байгаа цагт шинэ Монгол Улс оршин тогтнож байгаа гэдгийг эргэлзэхгүйгээр хэлж болно. Гэтэл сүүлийн үед УИХ-д эрх зүйн болон хүний эрхийн салбарт гарч байгаа нэлээд олон ухралт гарлаа. Тиймээс ч хэвлэлийнхэн сүүлийн 20 гаруй жилийн түүхэнд байгаагүйгээр эв нэгдлээ илэрхийлж, тэмцлийн тодорхой хэлбэрийг сонгож, цочроо өглөө. Өөрөөр хэлбэл, хэвлэлийнхэн маань "Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр"-ийг ялалтаар, амжилтаар угтаж чадсанд маш их баярлаж байгаа. Энэ цаг үед та бид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн хүрээнд нэлээд өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийж байна. Өмнөх парламентын үед эрх зүйн шинэчлэлийн үндсийн үндэс болсон Эрүүгийн цогц хуулийг шинэчлэн баталсан ч эцсийн найруулга хийж амжаагүй. Сонгуулийн дараа өмнөх Их хурал хаалтын чуулганаа ч хийх эрхгүй үндсэндээ ордноос хөөгдөөд гарсан. Түүний хар гай нь баталсан хуулиа эцсийн найруулгыг хийж чадаагүй явдал юм. Сонгуулийн дараа эрх баригчид эдгээр хуулийг буцаан татсан. Тухайн үед Ардын намын гишүүд ер нь энэ хуулиудыг бүхэлд нь буруу гэж үзэж байгаагаа мэдэгдэж байсан. Ялангуяа энэ хуулийн амин сүнс нь болсон гол ололтууд буюу хүний эрхтэй холбоотой заалтуудыг үгүйсгэж байгаагаа мэдэгдэж байлаа. Гэтэл өнөөдөр өргөн барьж байгаа хуулиуд тодорхой ухралттай байлаа. Түүнчлэн, УИХ-аар Засгийн газрын өргөн барьснаас ч хүнд нөхцөл байдлаар хуулиудыг гаргаж байгаа. Энэ нь хүний эрхийн хүрээнд маш том ухралт болж байгаа нь үнэхээр харамсалтай. Бүр цаашлаад Үндсэн хууль руу дайрах дайралт үе шаттайгаар маш амжилттай хэрэгжиж байгааг та бүхэн харж байгаа байх. Ийм байдлаар дарангуйллыг сонгох магадлал маш өндөр болж байна. Өнөөдөр их "эрч хүчтэй" эрх баригчид биднийг "бөмбөгдөж" байгаа. Монгол Улсад сул орон зай үлдэхгүй болтол зай завсаргүй "бөмбөгдөж" байна. Гэхдээ бид өөрсдийнхөө их үнээр олж авсан эрх чөлөөнийхөө төлөө энэ их "эрч хүчний" эсрэг сөрөөд зогсч чадна. Илүү гэдгээ харуулж, ардчилсан тогтолцоогоо хамгаалах ёстой. Түүний нэг нь энэхүү эрх зүйн хуулиуддаа хүний эрхийн, эрх чөлөөнийхөө нөхцөл байдлыг хангаж, хамгаалж үлдэх цаг үе ирээд байна" гэлээ.

## Сонсголгүй иргэдийн эрх ашиг зөрчигджээ

Үүний дараа Засгийн газрын төвшинд ажлын хэсгийн ахлаж байгаа Хууль зүй дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын санал дүгнэлтийг танилцууллаа. Дэд сайдын санал, дүгнэлтийг сонссоны дараа хэлэлцүүлэгт оролцсон төлөөллүүд хуулийн талаар санал дүгнэлтээ хэлсэн юм. Энэ үеэр Монголын өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч Ж.Батзоригт "Одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41.3.3-т зааснаар хохирогч, гэрч, шинжээчийг байцаахад байлцаж тэдгээрт асуулт тавих эрхийг огт байхгүй болгох гээд байна. Учир нь бид гэрч, хохирогч, шинжээчээс асуух асуултыг буюу өмгөөллийн эрхийг үгүй болгочихсон. Өмгөөлөгчид Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар олгогдсон эрхийг мөрдөн байцаагчийн зүгээс гэрч, шинжээчид хууль бусаар нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн бодит байх, шинжээчийн дүгнэлтээс тодорхойгүй эргэлзээтэй зүйлсийг нэг мөр болгон тодруулах, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой заалт бий. Гэтэл үүнийг хассан нь хүний эрхийг хамгаалах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцээний талуудын тэгш эрхтэй оролцох асуудалд ухралт болсон" гэв. Харин Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хуульч, өмгөөлөгч Н.Арвинтариа "Өргөн бариад байгаа хуулийн төслөөс нэг зүйлийг хасаад өгөөч гэж санал хэлмээр байна. Хуулийн 25 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт "Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүнээс мэдүүлэг авахдаа хэлмэрчийг оролцуулах боломжгүй бол түүний зөвшөөрсөнөөр бичгээр асуултад тавьж, мэдүүлэг авч болно" гэсэн зүйл заалт байна. Ингэж огт болохгүй. Энэ бол сонсголгүй буюу хэл ярианы бэрхшээлтэй хүмүүсийг шууд ялгаварлан гадуурхаж байгаа заалт. Учир нь эдгээр хүмүүс хүний ярьж байгааг бүрэн ойлгохгүй дээр нь бичгээр хариулт өгнө гэдэг байж болохгүй. Өнөөдөр 12 дугаар анги төгсч байгаа сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай дунд сургуулийн сурагчид 3-4 дүгээр ангийн хүүхдийн хэмжээнд бичгийн боловсрол эзэмшиж гарч байна. Тэгвэл эдгээр хүүхдүүд хуулийн хүнд үг хэллэгүүдийг бүрэн ойлгоод, буцаагаад бичгээр хариулна гэж байхгүй. Тиймээс энэ заалтыг авах хэрэгтэй" гэсэн юм. Энэ мэтээр хэлэлцүүлэгт оролцсон 30 гаруй салбарын төлөөлөл хуулийн төсөлтэй холбоотой олон санал гаргалаа. Хурлын төгсгөлд УИХ-ын гишүүн Ж.Батзандан "Өнөөдрийн хэлэлцүүлэгт оролцсон судлаачид, практик дээр ажиллаж байгаа өмгөөлөгч, хуульчдын саналууд маш үнэ цэнэтэй байлаа.

Тухайлбал, МУИС, ХЗС, Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, Хуульзүйн ухааны доктор О.Мөнхсайханы 11, Хуульч Н.Ариунболдын гурван санал, Хууль зүйн сайд асан Х.Тэмүүжингийн дөрвөн чухал санал, Монголын өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч Ж.Батзоригтийн гаргасан өмгөөллийн эрхийг хангах тухай гээд маш олон үнэтэй санал гарлаа. Би УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны гишүүний хувьд та бүхэнтэй санал нэг байгаа. Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлдэх УИХ-ын ажлын хэсэг зарим талаар судлаачдын байр суурийг сонсохгүй байна. 65 суудалтай улс төрийн хүчин зарим хуулийг муйхарлан хүч түрж батлах оролдлого хийж байгаа. Бид энэ болгоныг таслан зогсоож, хууль батлах процесст эрүүл ухааныг, шинжлэх ухааныг , мэргэжлийн чадвар, оюун ухааныг тусгах ёстой. Тиймээс ч өнөөдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа юм. Ардчилсан намын бүлэгт хуулиар олгогдсон зарчмын зөрүүтэй санал гаргах эрх нь байгаа. Энэ хүрээндээ та бүхний гаргасан үнэтэй саналуудыг оруулах болно" гэсэн юм.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.**
**2 давхар. 209, 211 тоот**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо"-той хамтарч ажиллана

БСШУСЯ "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо"-ны тэргүүн Д.Гэрэл нарын хүмүүсийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр талууд харааны бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн боловсролын үйлчилгээний талаар харилцан санал солилцож, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хамтран ажиллах чиглэлээ тодорхойлов. Улмаар БСШУСЯ, "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо"-той харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтран ажиллахаар боллоо. БСШУСЯ, "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо"-той харааны бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших адил тэгш боломжийг боловсролын бүх түвшинд өргөжүүлэх, монгол брайль стандартыг боловсронгуй болгох, онлайн толь бичигтэй болох, согогзүйч багш нарыг бэлтгэх, тоног, төхөөрөмжийг сайжруулах, харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийг бие даасан дотуур байртай болгох зэрэг асуудлаар хамтран ажиллахаар тохиролцлоо.

БАЙНГЫН ХОРОО

## БНХАУ-аас авах нэг тэрбум ам.долларын зээлийн хэлэлцээрийг шинэчлэв

Б.ТОГТОХ

Өчигдөр улс төрийн хоёр том хүчин болох МАН, АН Ерөнхийлөгчид нэр дэвшигчээ тодруулахаар Бага хурлаа хийж, дотоод сунгаа зохион байгуулсан учраас Төрийн ордон эзгүй шахам өнжив. МАН-ын 65 гишүүн Бага хуралдаа сууж, харин АН-ын гишүүд дотоод сунгаанд санал өгөхөөр намын үүр хороод руугаа давхиж байлаа. Гэсэн ч хуваарь ёсоор хуралдах хоёр байнгын хороо товлосон цагтаа хуралдаж, асуудлуудаа хэлэлцэж амжлаа. Тодруулбал, Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны өчигдрийн хуралдаанаар Засгийн газраас өнгөрөгч дөрөвдүгээр сарын 11-нд өргөн мэдүүлсэн Эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэж, тус байнгын хороонд харьяалагддаг Батлан хамгаалах болон Гадаад харилцааны яамны тайлан мэдээг сонслоо. Мөн БНХАУ-ын дарга Си Зиньпин манай улсад айлчлах үедээ ярилцаж тохиролцсон нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн асуудал болон өмнөд хөршийн Засаг захиргааны онцгой бүс Макао улсаас ялтан шилжүүлэх хоёр улсын хэлэлцээрийг зөвшилцөхөөс гадна, хоёр улсын эрүүгийн хэргээр эрхзүйн туслалцаа харилцан үзүүлэх хэлэлцээрийг хэлэлцэн баталлаа. Байнгын хорооны хуралдааны эхэнд Үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэх үед аудитын байгууллага Батлан хамгаалах болон Гадаад харилцааны яаманд хийсэн аудитын тайланг танилцууллаа. Улмаар, Батлан хамгаалах яам 100 хувь, Гадаад харилцааны яам 64 хувийн хэрэгжилттэй байна гэж үнэлжээ. Хуралдааны хоёрдугаар асуудлын хувьд манай улсын Засгийн газар, БНХАУ-ын Экспорт-Импорт банк хооронд хоёр жилийн өмнөөс яригдсан нэг тэрбум ам.долларын зээлийн асуудал байсан юм. Энэхүү зээлийн ерөнхий нөхцөл нь 20 жилийн хугацаатай, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа долоон жил, зээлийн хүү жилийн хоёр хувь бөгөөд хэрэгжүүлэх төсөл тус бүрийн 85 хувийг БНХАУ-ын Экспорт-Импорт банк, 15 хувийг Монгол Улсын Засгийн газар санхүүжүүлэхээр байжээ. Харин Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн санхүүжилтийн хүндрэлтэй байдлыг харгалзан уг зээлийн нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулж зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг 95 хувь зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр Хятадын талтай тохиролцсон байна. Дээрх өөрчлөлтийг байнгын хорооны гишүүд дэмжсэнээр чуулганы хуралдаанд хэлэлцүүлэхээр болов. Мөн энэ өдөр Азийн хөгжлийн банкнаас авах нийгмийн халамжийг дэмжих зорилготой 150 сая ам.долларын зээлийн хэлэлцээрийг ч гишүүдийн олонхи дэмжлээ. Макао улстай хийх ялтан шилжүүлэх хэлэлцээрийг гишүүдийн олонхи нь дэмжиж, чуулганы хуралдаанаар хэлэлцэхээр боллоо. энэ өдөр хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хоёр гишүүний өргөн мэдүүлсэн нэг утга агуулга бүхий хуулийн төслийг хэлэлцэв. Тодруулбал, УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 12 гишүүний өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуулийн төслийг тус тусад нь хэлэлцэж, хуралдааны төгсгөлд дээрх хоёр хуулийн төслийг цаашдаа нэгтгэн хэлэлцэхээр шийдэлд хүрсэн юм. Улмаар хуулийн төслүүдийг нэгтгэж ажлын хэсэг байгуулав. Хуралдааны төгсгөлд мөн л Үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэн дэмжлээ.

# ҮЗЭЛ БОДОЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# МАН-ААС М.ЭНХБОЛД илүүрхэж, АН НЭР ДЭВШИГЧЭЭ тодруулж чадсангүй

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Ху намаас өчигдөр мэдээлэл хийх зар тараасан ч Ерөнхийлөгчийн сонгуультай холбоогүй сэдвээр хийв. Хэрвээ нэр дэвших хүнээ тодорхой болгочихвол хэзээ ч хамаагүй Бага чуулганаа хийх ирц хангалттай гэсэн мэдээлэл өгчээ. МАХН-ын дарга Н.Энхбаярын хувьд нэр дэвших хүсэлтээ илэрхийлсэн ч ял эдэлж байсан учраас боломжгүй гэсэн хариулт аваад байгаа юм. Энэ тохиолдолд хоёр намын аль нэгийг нь дэмжиж орохын тулд хэн илүү ашигтай санал тавихыг анаж суугаа гэх бор шувуу ч саарал ордонд нисч эхэлжээ.

## М.Энхболд үнэмлэхүй олонхийн санал авлаа

Тусгаар тогтнолын ордонд Бага хурал 11.00 цаг өнгөрч байхад эхлэв. Хуралдааны өмнөхөн МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан сэтгүүлчдэд мэдээлэл хийж, Удирдах зөвлөлийн шийдвэр болон хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл өглөө. Өнгөрөгч мягмар гарагт хуралдсан намын Удирдах зөвлөлийн хуралдаанд таван нэр дэвшигч нэрсээ бүртгүүлжээ. Тодруулбал, УИХ-ын дарга М.Энхболд, Шадар сайд У.Хүрэлсүх, УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ө.Энхтүвшин, Ц.Нямдорж нар өрсөлдөж гурван нэр дэвшигч нэрээ татсанаар өрсөлдөөн УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын гишүүн Ц.Нямдорж нарын дунд өрнөнө гэдгийг Д.Амарбаясгалан дарга онцолсон. Бага хуралд 330 сум, 21 аймаг, нийслэлийн есөн дүүргийн төлөөлөл болох 310 гишүүн оролцов. Гэвч "Хэн ялалт байгуулах нь эртнээс тодорхой байсан. Мэдээж ганцаараа торойх нь эвгүй учраас Ц.Нямдорж гишүүн өрсөлдөөнд оролцсон төдий. М.Энхболд дарга Ерөнхийлөгчид өрсөлдсөнөөр УИХ-ын даргын суудал дэд дарга Ц.Нямдоржид очно" гэх таамаг яриа Тусгаар тогтнолын ордонд хэдийнэ гарчихсан байлаа. Энэ таамаг ч үнэний ортой гэдэг нь Бага хуралд оролцсон гишүүдийн өгсөн "хайрцагласан" саналаас харагдаж байлаа. Ц.Нямдорж гишүүн тийм ч сул өрсөлдөгч биш. Гэтэл хуралдаанд оролцсон 222 гишүүн намын даргадаа санал өгч, 37-хон хүн Ц.Нямдорж гишүүнд санал өгсөн юм. Нийт гишүүдийн 85 хувь нь М.Энхболд даргад итгэл үзүүлсэн гэхээр арай л үнэмшил муутай сонсогдож байсныг нуугаад яахав. Ц.Нямдорж гишүүн ч энэ дүн мэдээг урьдаас таамаглаж байсан гэдгээ хэлж байлаа. Тэрбээр, үнэмлэхүй олонхийн санал авсан М.Энхболд нэр дэвшигчийн духан дээр нь үнсч амжилт хүсээд "Цочирдох юм надад байхгүй. Цайныхаа цацлыг "Төрийн минь сүлд өршөө" гэж тэнгэрт өргөдөг ард түмэн. Ийм ард түмний төрийн тэргүүн байна гэдэг нэг талаас асар их хариуцлага нөгөө талаас аз байдаг. Найман жил болж, одоогийн Ерөнхийлөгчийн хугацаа нь дуусч байна. Шинэ Ерөнхийлөгч орох нь ойлгомжтой болж байна. М.Энхболд дарга энэ сонгуульд ялж, төрийн тэргүүн болох ерөөлийг дэвшүүлж, амжилт хүсч байна. Би та бүхэнтэй хамтарч М.Энхболд даргын сонгуульд чадах ядахаараа зүтгэнэ гэдгийг энэ индэр дээрээс хэлье. Бас "намайг Ерөнхийлөгчид нэр дэвшээрэй, битгий татгалзаарай" гэж дэмждэг хүмүүс цөөнгүй бий. Тэдэнд хандаж хэлэхэд, Ц.Нямдорж явж байна гэж бодоод М.Энхболд даргыг дэмжиж өгөөрэй. Тэнгэр биднийг өршөөх болтугай, Төрийн сүлд биднийг ивээх болтугай" хэмээлээ. 222 гишүүний саналаар намаасаа Ерөнхийлөгчид өрсөлдөх эрхээ авсан УИХ-ын дарга М.Энхболд "Нам надад асар том үүрэг даалгавар өглөө хэмээн энэ их хүндлэл найдварыг хөсөрдүүлэхгүйн төлөө би бүхий л боломжоо шавхан зүтгэх болно" хэмээлээ. Наймдугаар бага хурлын хоёрдугаар сэдэв нь Ерөнхийлөгчид өрсөлдөх эрхээ авсан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцэх байсан. Энэ ёсоор ч үдээс хойшхи хуралдаанаар нэр дэвшигчийнхээ мөрийн хөтөлбөрийг хэлэлцэв. Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлээгүй учраас нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг хаалттай горимоор хэлэлцэж, 18.00 цагт тус намын Бага хурал өндөрлөлөө.

## АН–ынхан анай л мөнгө тарааж, саналын маргаан гаргав

АН-аас Ерөнхийлөгчид горилж буй таван нэр дэвшигчээс нэгийг сонгох, намын дотоод сунгаа өчигдөр өглөө 10.00 цагт эхэлсэн юм. 21 аймаг, 330 сум, нийслэлийн есөн дүүрэг, 152 намын үүр, хороодоор дамжуулан 180 мянган гишүүнийхээ саналыг авах дотоод сонгууль өмнөхийн адил маргаан мэтгэлцээнтэй өрнөв. Дотоод сонгуульд Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг, УИХ-ын гишүүн асан Х.Баттулга, Р.Амаржаргал, УИХ-ын гишүүн Лу.Болд, БНН-ын дарга асан Б.Жаргалсайхан нар өрсөлдөж, эв нэгдлийн гэрээ хүртэл байгуулав. Дотоод сонгуулийн үеэр намын дотоод журмаа зөрчихгүй байх, нэгнийхээ ялалтыг зүй ёсоор хүндэтгэх, хууль дүрмээс гажууд үйлдэл гаргахгүй хэмээн гэрээнд гарын үсэг зуржээ. Мэдээж дотоод сонгууль учраас сурталчилгааг хаагаагүй. Тэр ч утгаараа сошиал орчинд нэр дэвшигчид нэг нэгнийхээ өмнөх булхайг гаргаж тавих, сурталчилгаагаа ил тодоор хийсээр санал хураалтыг дуусгалаа. Санал хураалт 20.00 цагт дууссан бөгөөд ирц 60 гаруй хувьтай байжээ. Түүнчлэн, зарим нэр дэвшигч ил тод мөнгө тарааж байна гэсэн санал гомдлоос гадна өмнөх сонгуульд оролцож байсан гишүүд нь Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдээ санал өгөхөөр ирэхэд санал өгөх эрхгүй болсон гэх гомдол олон гарав. Тэр ч байтугай АН-ын даргаар ажиллаж байсан Н.Алтанхуягийн санал өгөх эрхийг хассан асуудал ч өчигдөр гарсан юм. Саналын маргааны талаар сонгууль зохион байгуулагчид тайлбар өгөхдөө "Намаас гишүүдийн нэрийг лацдаж ирүүлсэн. Тиймээс намаас ирсэн нэрний дагуу санал авч байна" хэмээжээ. Санал хураалтын эцсийн дүн 22.00 цаг орчим гарна хэмээн эх сурвалж мэдээлсэн ч өнөөдөр хариу гарах боломжгүй гэдгийг АН-ын хэвлэлийн албанаас мэдээллээ.

## Ерөнхийлөгчид өрсөлдөгч М.Энхболд гэж хэн бэ

Энэ хүний намтар дэлгэсэн тэрлэг шиг. Улс төрийн тогоонд 30 гаруй жил явахдаа сайн, муугаар чамгүй хэлэгдэж явсан учраас улс төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан он жилүүд нь ард түмний нүдэнд илхэн билээ. Нэр дэвшигч М.Энхболдын дэлгэрэнгүй намтартай танилцана уу.

**Төрсөн он:** 1964 оны 7 дугаар сарын 19-ний өдөр,
**Төрсөн газар:** Улаанбаатар хот,

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 1982 онд | Нийслэлийн 10 жилийн 1 дүгээр лаборатори дунд сургууль, |
| 1987 онд | Монгол Улсын Их сургуулийг төлөвлөгч-эдийн засагч мэргэжлээр төгссөн, |
| 1996 онд | Япон улсад Төрийн захиргааны байгууллагын удирдлага, зохион байгуулалтын асуудлаар мэргэжил дээшлүүлсэн, |
| 1998 онд | ХБНГУ-д Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн, |
| 2000 онд | Эдийн засгийн магистр, |
| 2002 онд | НҮБ-ын Олон улсын мэдээлэл зүйн Академийн жинхэнэ гишүүн, |
| 2003 онд | БНСУ-ын Гуан-Үн их сургуулийн төрийн захиргааны Хүндэт доктор, |
| 2006 онд | Орхон их сургуулийн Хүндэт доктор, |

**Ажил эрхлэлт:**

| | |
|---|---|
| 1987-1989 онд | Улаанбаатар хотын Ахуйн үйлчилгээний удирдах газарт эдийн засагч, |
| 1989-1991 онд | Нийтийн аж, ахуйн үйлчилгээний яамны төлөвлөлт аж ахуйн механизмын хэлтэст мэргэжилтэн, |
| 1991-1992 онд | Улаанбаатар хотын АДХГЗ-ны Ахуйн үйлчилгээний хэлтсийн дарга, |
| 1992-1996 онд | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч, |
| 1996-1998 онд | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, |
| 1999-2005 онд | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, |
| 2005 оноос | Монгол Улсын Их Хурлын гишүүн, |
| 2006-2007 онд | Монгол Улсын Ерөнхий сайд, |
| 2007-2012 онд | Монгол Улсын Шадар сайд, |
| 2012-2016 онд | Монгол Улсын Их Хурлын дэд дарга, |
| 2016 оноос | Монгол Улсын Их Хурлын дарга. |

**Улс төрийн сонгуульт ажил:**

| | |
|---|---|
| 1990 онд | Монгол Ардын Намд элссэн, |
| 1991-1992 онд | Нийслэлийн МАН-ын 214 дүгээр үүрийн дарга, |
| 1992-1997 онд | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн МАН-ын хорооны дарга, |
| 1997-2006 онд | Нийслэлийн МАН-ын хорооны дарга, |
| 2005-2007 онд | Монгол Ардын Намын дарга, |
| 2007-2012 онд | МАН-ын нарийн бичгийн дарга, |
| 2013 оноос | МАН-ын дарга |
| 1998 оноос | МАН-ын Удирдах зөвлөлийн гишүүн, |
| 1997 оноос | МАН-ын Бага хурлын гишүүн, |
| | МАН-ын 21, 22, 23, 24, 25, 26, 27 дугаар Их Хурлын төлөөлөгч, |
| | МАН-ын 21 дүгээр Их хурлаас "ШИНЭ ҮЕ" жигүүрийн санаачлагч, |
| 1995 онд | "Залуучууд хөгжил төв"-ийн үүсгэн байгуулагч, |
| 1997 онд | Монголын ардчилсан социалист залуучуудын холбоо буюу одоогийн Нийгмийн ардчилал, монголын залуучуудын холбоог үүсгэн байгуулагч, |

**Төрийн бус байгууллагын сонгуульт ажил:**

| | |
|---|---|
| 2000-2012 | Үндэсний Олимпийн хорооны тэргүүлэгч гишүүн, |
| 2008 оноос | Монголын морин спорт, уяачдын холбооны Ерөнхийлөгч, |
| 2009 оноос | Шинжлэх Ухааны Академийн Тэргүүлэгч гишүүн, |
| 2011 оноос | "Манзушир хутагт" сангийн Тэргүүн. |

Дугаарын 60 мөр

# Сэтгүүлчид нохойд барьдаг мод биш

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Шинийн нэгний өглөө, он солигдох тэр мөчид сэтгүүлчид л ажиллаж байдгийг та бүхэн мэдэх хойно. Чухамхүү мэргэжилдээ дэндүү хайртай хүмүүс л энэ ажлыг хийдэг байх. Үүнийг зарим эрх мэдэл бүхий албан тушаалтнууд, албан байгууллагууд ойлгодоггүйг эрх чөлөөгөөр амьсгалж буй эл өдөр хэлэх нь зөв байх. Шулуухан хэлэхэд, нохойд барьдаг мод шиг санах нөхөр ч байх л юм. Нэр алдар олох гэсэн албан тушаалтнууд сэтгүүлчдийг хаа явсан газартаа дагуулж, гоёлын зүүлтээ олонд харуулах гэж элдэвлэдэг хүүхнүүд шиг аашлах нь бий. Төрийн түшээд, сайд дарга нар орон нутагт томилолтоор ажиллах болбол хамгийн түрүүнд " Хэвлэлийнхэн явах юм уу, ямар ямар телевиз дагах юм " гэцгээдэг. Энэ нь орон нутагтаа сэтгүүлчид тэр дундаа телевизийнхнийг хуйлруулсан хүн очих гэсэн хэрэг. Санаачилсан, сэдсэн, эхлүүлсэн ажил нь нийгэмд, орон нутагт үр дүнтэй болбол түүнийгээ түмэнд түгээж болно. Хэдэн ч сэтгүүлч дагуулж болно. Гагцхүү хүн чанартай байх ёстой. Өөрөө ланд-200, 570 унан сураггүй хаяж одсоноо ажилчдын автобус эсвэл микронд чихэлдэх сэтгүүлчдийг хоцорч ирлээ энэ тэр болох нь хачирхалтай. Эсвэл хаа нэгтээ хонох хэрэг гарвал өөрсдөө хамгийн сайхан, тохь тухтайд нь морилчихоод, дагуулж яваа хэдээ нүүр гар угаах усгүй өрөөнд өвөр өвөрт нь унтуулах албан тушаалтнууд ч байдаг л юм. Саяхны жишээ татахад, УБТЗ -ынхан сэтгүүлчдийг Замын –Үүд рүү дагуулж явахдаа хатуу хандсан байх юм. Тэднийг галт тэргэнд суулгахын өмнө, өөрөөр хэлбэл өмнөх орой нь гурван хуушуур, өглөө цайгүй маргааш өдөр 14 цагт хагас порц гуляш, орой нь хүний дөрөв дөрвөн бууз төдийхнөөр хооллосон байдаг. Хэрэв сэтгүүлчид хооллохыг шаардаагүй бол өдрийнхөө хоолоор явсаар маргааштай залгах байсан биз ээ.

Ингэхдээ яасан их хэл ам таталдаг юм гэж ирээд загнасан, гал тэрэгний үйлчлэгчийн ширүүн догшин авирын талаар сэтгүүлчид өнөөдөр ч ярьсаар байгаа. Ийм үйлдлийг юу гэж ойлгох вэ. Сэтгүүлчийг дэндүү дорд үзсэн хэрэг бус уу. Нөгөөтэйгүүр, УИХ-ын болоод орон нутгийн сонгууль болохоор хэн бүхэн сэтгүүлчдэд хайр зарлан "Нутгийн дүү ахдаа, эгч дээ туслаарай" хэмээн урдуур хойгуур эргэлдэх мөртөө сонгуулийн маргааш танихаа байж, зарим нь амласан мөнгө төгрөгөө "Унасан хүнээс юу авах гэсэн юм. Би төдөн зуун саяар шатсан" хэмээн ширэн нүүр гаргах нь бий. Өнөөдөр хэвлэл мэдээллийн салбарт таван мянга орчим хүн ажиллаж байгаагийн 14 хувь нь удирдах ажилтан 44 хувь нь сэтгүүл, үлдсэн нь инженер техникийн болон захиргаа, үйлчилгээ, туслах ажилтнууд байдаг талаар статистик мэдээнд дурдагдаж. Сэтгүүлч ажиллаж байгаа учраас хэвлэл мэдээллийн байгууллага оршин тогтнож буй. Нийт ажиллагсдын 44 хувийг эзэлж байгаа сэтгүүлчдийн хэчнээн нь үнэнийг эрэлхийлсэнийхээ төлөө шүүхэд дуудагдаж, эрх мэдэлтнүүдийн нэр хүндэд халдсан, гүтгэсэн хэрэгт унаж байгааг хэлж мэдэхгүй байна. Монголын нийгэмд эрх мэдэл бүхий албан тушаалтнууд л хөрөнгөжиж, хамгийн тансаг амьдралаар амьдарч байгаа нь үнэн биз дээ. Сэтгүүлч тэдний хэрхэн хөрөнгөсөн талаар баримт дэлгэдэг ч түүнийгээ нотолж чаддаггүйн улмаас буруудлаг. Төрөөс төрсөн тэрбумтнууд бүгд эрх мэдэлтэй байх үедээ хууль бус үйлдлээ дарж, бусдын нэрээр зувчуулж амжсан байдагт л үнэнийг мөртэй үзэгний хошуу тэнд тулаад мохдог. Ийм л нийгэм, цаг үе дор нийгмийн сайн сайхны төлөө дуу хоолой нь болон усан бороо улаанаараа эргэлдэх шуурга сөрөн гүйх сэтгүүлчийг нохойд барих мод адил үзэхийн эсрэг хамтдаа тэмцэе.


## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь "Авто зогсоол байгуулах ажлын зураг төсөв боловсруулах" болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 05 дугаар сарын 12-өдрийн 12 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 05 дугаар сарын 15–ний өдрийн 10.00 цагийн дотор ирүүлнэ үү.

**Налайх дүүрэг, 2-р хороо, Хуульчдын гудамж, Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-н байр, Худалдан авах ажиллагааны алба. Утас: 7023-2788**

# ДЭЛХИЙ

## Х.Клинтон: Би Ерөнхийлөгч болох байсан

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон өнгөрсөн жилийн арваннэгдүгээр сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдсан шалтгаанаа Холбооны мөрдөх товчооны дарга Жеймс Комитой холбожээ. Тэрбээр “Хэрэв Холбооны мөрдөх товчооны дарга Жейми Коми миний хувийн емэйлтэй холбоотой асуудлыг сонгуулийн өмнөхөн буюу аравдугаар сарын 28-нд дахин сөхөөгүй бол би Ерөнхийлөгч болох байсан” гэсэн байна.

Нью Йоркт энэ сарын 2-нд зохион байгуулагдсан үйл ажиллагааны үеэр сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгөхдөө Хиллари Клинтон энэ тухай дурссан аж. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль арваннэгдүгээр сарын 8-нд болсон. Гэвч сонгуулиас сар гаруйн өмнө Холбооны мөрдөх товчоо конгресст захидал илгээн, Хилларигийн хувийн емэйлтэй холбоотой асуудлыг сөхсөн байдаг. Гэсэн ч, эцэст нь гэм буруугүй гэх шийдвэр гаргасан удаатай. Тэгвэл өнөөгийн Ерөнхийлөгч Д.Трамп мөн түүнд хариу тайлбар хийгээд амжсан гэнэ. Хэзээний сошиал сүлжээний идэвхтэй хэрэглэгч Д.Трамп өөрийн твиттер хуудастаа “Коми бол Хилларитай учирсан сайн хүмүүсийн нэг. Тэр түүнд олон муу зүйл хийх боломжийг гаргаж өгсөн. Орос, Трампын хоёрын талаарх худал хуурмаг мэдээллийг Ардчилсан намынхан сонгуулийн ялагдлаа цагаатгах гэж ярьдаг. Гэтэл Трамп зүгээр л сонгуулийн кампанит ажлаа сайн хийсэн байж болохгүй юу” хэмээн жиргэжээ. Мөн тэрбээр эмэгтэй хүн байсан нь сонгуульд ялагдах шалтгаан болсон байхыг үгүйсгэхгүй байгаагаа хэлсэн байна.

## Афганистаны нийслэлд хүчтэй дэлбэрэлт боллоо

Афганистаны нийслэл Кабул хотод НАТО-ын цэргүүдийн сууж явсан машины цувааг онилсон хүчтэй дэлбэрэлт болж, найман хүн нас барж, 25 нь гэмтэж бэртжээ. Нөгөөтэйгүүр, энэ удаагийн халдлагыг хэт даврагч “Лалын улс” бүлэглэл үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрчээ.

Афганистаны Дотоод хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгчийн “AFP” агентлагт мэдээлснээр дэлбэрэлт АНУ-ын Элчин сайдын яам болон НАТО-ын төлөөлөгчийн газрын ойролцоох түгжрэл ихтэй автозам дээр болжээ. Хохирогчдын ихэнх нь энгийн иргэд байсан байна. Гэхдээ энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл одоогоор байхгүй байгаа юм. Харин НАТО-оос мэдээлснээр энэ удаагийн дэлбэрэлтэд гурван гадаад улсын цэргийн албан хаагч өртсөн ч, амь насанд нь аюулгүй гэжээ. Гэвч, яг аль улсын иргэн болох талаар тодорхой мэдээлэл өгөөгүй байна. Гэрч болон тухайн бүсэд ажиллаж буй Франц пресс агентлагийн зурагчны ярьж буйгаар дэлбэрэлтэд НАТО-ын MRAP гэх хоёр машин өртсөн бөгөөд тухайн үед зам дээр том нүх үүссэн байжээ. Мөн жирийн иргэний гурван машин өртснөөс нэг нь шатсан гэх мэдээлэл байна.

## В.Путин Д.Трамптай долдугаар сард уулзахаар товложээ





АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин нар утсаар ярьжээ. Тэдний ярианы гол сэдэв нь Сирийн өнөөгийн нөхцөл байдал болон анхны албан ёсны уулзалтын тов байсан аж. Цагаан ордноос мэдээлснээр тэдний яриа халуун дулаан уур амьсгал дунд өрнөсөн гэнэ.

Дэлхийн хоёр хүчирхэг гүрний ярианы сэдэв нь зургаа дахь жилдээ үргэлжилж буй Сирийн иргэний дайн. Тус асуудалд хоёр улс өөр өөр байр суурийг баримталдаг. АНУ-ын хувьд жирийн иргэдийн эсрэг химийн зэвсэг ашиглаж буй Сирийн Засгийн газрыг буруутгах хандлагатай байдал бол ОХУ Ассадын Засгийн газрыг дэмждэг билээ. Тэгвэл хоёр орны тэргүүний утасны цаадах энэ сэдвийн яриа нэлээд удаан хугацаанд үргэлжилж, дайн, хүчирхийллийг эцэслэхэд бүх талууд нэгдэж, зорилгодоо тууштай байхад санал нэгдсэн байна. Трампын ойрын эх сурвалжийн мэдээлснээр тэд мөн Сирид энх тайвныг тогтоох янз бүрийн хувилбарын талаар ярилцсан байх бөгөөд бүр “Аюулгүйн бүс” байгуулах санал хүртэл гаргасан байна.

Тэдний ярианы үеэр хөндөгдсөн нэг асуудал нь төрийн тэргүүнүүдийн анхны уулзалтыг тов байв. Тодруулбал, ирэх долдугаар сард Германд болох Их 20-ын бүлгийн уулзалтын үеэр тэд хоёр талт уулзалт хийхээр тохирсон байна.

## Хойд Солонгос америк багшийг баривчилжээ

БНАСАУ-ын төрийн мэдлийн KCNA агентлаг тус улсын нийслэл Пхеньянд америк багшийг баривчилсан тухай мэдээлжээ. Тони Ким гэх америк гаралтай эрэгтэй багш Хойд Солонгосын нэр хүндтэй их сургуульд хэдэн долоо хоног лекц уншсаныхаа дараа нутаг буцахаар нисэх онгоцны буудалд ирэхдээ баривчлагдсан байна.

АНУ-Пхеньяны харилцаа хурцадмал байгаа энэ үед Хойд Солонгост баривчлагдсан гурав дахь америк хүн нь тэр аж.

Тони Ким өнгөрсөн сарын 22-нд Пхеньяны нисэх онгоцны буудлаас баривчлагдсан байна. KCNA агентлаг тэдний баривчлагдсан шалтгааныг “БНАСАУ-ыг унагах зорилготой дайсагнасан үйл ажиллагаа хийсэн” хэмээн тайлбарлажээ.

Ким Пхеньяны шинжлэх ухааны сургууль “PUST”-д нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр лекц уншихаар тус улсад очсон байна. Ёнхап агентлагийн мэдээлснээр Ким эдүгээ 55 настай бөгөөд Хойд Солонгосын орон нутгийн хүүхдүүдэд боловсрол олгох үйл ажиллагаанд оролцож байжээ.

# Солонгосыг удирдах магадлалтай МҮН ЖЭ ИН ГЭЖ ХЭН БЭ




Б.ДАВААХҮҮ

БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль болоход тав хоног үлдлээ. Тэгвэл сонгууль угтсан сүүлийн үеийн санал асуулгад Ардчилсан намаас нэр дэвшигч Мүн Жэ Ин илт давуугаар тэргүүлж эхэлсэн. Тодруулбал, БНСУ-ын хувийн хэвшлийн судалгааны байгууллага “real meter”-ын өнгөрсөн сарын 27-29-ний өдрүүдэд явуулсан санал асуулгад Мүн Жэ Ин 42.6 хувийн саналаар тэргүүлсэн байна. Харин түүний хүчтэй өрсөлдөгч Ардын намаас нэр дэвшигч Ан Чёл Сү 20.9 хувийн дэмжлэг хүлээсэн билээ. Ийнхүү хамгийн өндөр рейтингтэй, БНСУ-ын дараагийн Ерөнхийлөгч болох магадлалтай Мүн Жэ Ин гэж чухам хэн бэ.

Мүн Жэ Ин 1953 оны арванхоёрдугаар сарын 22-нд Өмнөд Солонгос улсын Коджедо аралд таван хүүхэдтэй айлын ууган хүү болон мэндэлжээ. Түүний эцгийг Мүн Ён Хюн, харин ээжийг нь Кан Хан Ок гэдэг бөгөөд тэд 1950 онд Солонгосын хойг дайны хөлд нэрвэгдэх үед БНАСАУ-ын Өмнөд Хамгён аймгаас АНУ-ын “MEREDITH VICTORY” гэх ачааны хөлөг онгоцонд сууж, Коджедо арал руу дүрвэн ирсэн цагаачдын нэг байсан гэдэг.

Тэдний гэр бүл Коджедод суурьшиж, эцэг нь “Geoje POW Camp” үйлдвэрт ажиллах болжээ. Харин Өмнөд Солонгост дүрвэн ирж суурьшаад, гурав дахь өвөлтэйгөө золгохдоо анхны үрээ өлгийдөн авсан нь БНСУ-ын дараагийн Ерөнхийлөгч болох магадлал туйлын өндөр яваа Мүн Жэ Ин байсан юм.

Удалгүй тэднийх Бусан хот руу нүүдэллэж, тэнд Жэ Ин “Кюннам” ахлам сургуульд суралцжээ. Мүн Ён Хюных туйлын ядуу зүдүү амьдралтай байсан гэдэг. “Хангёл” сонинд бичсэнээр, эрдэнэ шишийн үрийг үдийн хоолондоо зооглодог байсан бөгөөд түүгээрээ бүтэн өдрөө даадаг байсан гэнэ. Үүгээр зогсохгүй сарын төлбөрөө төлөөгүй гэх шалтгаанаар хичээлийн танхимаасаа хөөгдөж байсан удаатай аж. Жэ Ин ахлах сургуулиа төгссөний дараа “Кюнхэ” их сургуульд хуулийн чиглэлээр дэвшин суралцсан байна.

Гэвч, 1975 онд хэрэг мандах нь тэр. Тухайн үед их сургуульд хуулийн чиглэлээр суралцаж байсан Мүн Жэ Ин Ерөнхийлөгчийн засаглалын эсрэг Ардчилсан хөдөлгөөнд оролцсон гэх шалтгаанаар баривчлагдан хоригдож байжээ. Тухайн үед БНСУ-ын Ерөнхийлөгчөөр эдүгээ хэд хэдэн хэрэгт буруутгагдан хоригдож буй экс Ерөнхийлөгч Пак Гын Хегийн эцэг Пак Чун Хе ажилладаг байв. Пак Чун Хег дарангуйлагч байсан гэж тодорхойлох нэгэн байдаг ч, БНСУ-ын өнөөгийн хөгжлийн эхлэлийг тавьсан гэж үнэлэх хүмүүс олон байдаг юм. Харин тухайн үед түүний дэглэмийг эсэргүүцсэн Ардчиллын төлөөх хөдөлгөөний дараа Мүн Жэ Ин баривчлагдан, Сөүлийн шоронд хоригдох болжээ. Буруутгагдсан үндэслэл нь ч түүнийг их сургуулиасаа хөөгдөхөд хүргэсэн байна. Дараа нь тэр хүчээр шахам цэрэгт явж, тэндээ тусгай хүчинд багтаж чаджээ. Улмаар 1976 онд Панмунжон тосгонд Хойд Солонгосын арми Өмнөд Солонгос буюу НҮБ-ын цэргүүдтэй мөргөлдөөн үүсгэхэд тэнд томилогдсон тусгай хүчнийхний багт Мүн Жэ Ин багтаж байжээ.

> ...Гэвч, 1975 онд хэрэг мандах нь тэр. Тухайн үед их сургуульд хуулийн чиглэлээр суралцаж байсан Мүн Жэ Ин Ерөнхийлөгчийн засаглалын эсрэг Ардчилсан хөдөлгөөнд оролцсон гэх шалтгаанаар баривчлагдан хоригдож байжээ. Тухайн үед БНСУ-ын Ерөнхийлөгчөөр эдүгээ хэд хэдэн хэрэгт буруутгагдан хоригдож буй экс Ерөнхийлөгч Пак Гын Хегийн эцэг Пак Чун Хе ажилладаг байв...

Тэрбээр 1978 онд цэргээс халагдсан. 1980 онд дахин Кюн Хе их сургуулийг төгсчээ.

Үүний дараа 1982 онд тухайн үед өмгөөлөгч байсан Ну Мү Хёньтой хамтран хуулийн компаниа байгуулж байсан гэдэг. 2002 оны арванхоёрдугаар сард түүний хамтран зүтгэгч Ну Мү Хён Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж, Жэ Ин Бусан дахь сонгуулийнх нь штабын даргаар ажиллаж байсан гэнэ. Харин Ну Мү Хён 2003 онд БНСУ-ын 16 дахь Ерөнхийлөгчөөр сонгогдсны дараа Мүн Ерөнхийлөгчийн тамгын газарт орж ажилласан байна. Харин 2009 онд Ну гэрийнхээ хойд талын ууланд очиж, амиа егүүтгэн нас барахад ч Мүн Жэ Ин хамтран зүтгэгчээ эцсийн замд нь үдэн, оршуулгын ёслолыг удирдаж байжээ.

Тэр бол БНСУ-ын 16 дахь Ерөнхийлөгч татвар, санхүүгийн асуудлаар мэргэшсэн өмгөөлөгч асан Ну Мү Хёны ойрын, дотны анд байсан юм. Харин эдүгээ тэрбээр өөрөө Ерөнхийлөгч болохоор нэр дэвшиж байгаа юм.

Түүний үхлийн дараа ч тэрбээр улстөрийн үйл хэргээ үргэлжлүүлсээр байсан гэдэг. 2011 оны есдүгээр сард “Инноваци ба хамтын ажиллагаа” компанийг үүсгэн байгуулж, төлөөлөгчөөр нь ажиллах болсон. Дараа жил нь буюу 2012 оны дөрөвдүгээр сард 19 дахь удаагийн бүх нийтийн сонгуулиар “Ардчилал эв нэгдлийн нам”-ыг үүсгэн байгуулж, нэр дэвшсэн байна. Ардчилсан нам дотооддоо эхний шатны сунгааг наймдугаар сарын 25-нд хийж, улс даяар 13 бүс нутгаас нэг нэг нэр дэвшигчийг тодруулжээ. Улмаар шийдвэрлэх шатны санал хураалтыг мөн оны есдүгээр сарын 16-нд товлосноор Мүн Жэ Ин 56.5 хувийн дэмжлэг хүлээж, “Ардчилсан нам”-аас Ерөнхийлөгчид нэр дэвших эрхтэй болж байв.

Ингээд 2012 оны арванхоёрдугаар сарын 19-нд Ерөнхийлөгчийн сонгууль болоход Сэнүри намаас нэр дэвшигч Пак Гын Хетэй өрсөлдөн ялагдаж байжээ.

2016 оны дөрөвдүгээр сард болсон 20 дахь удаагийн бүх нийтийн сонгуульд тэр нэр дэвшээгүй. Харин энэ оны дөрөвдүгээр сарын 3-нд намаасаа Ерөнхийлөгчид нэр дэвшихээ зарласан байдаг.

Тэр мөн гэрлэсэн, хоёр хүүхэдтэй. Ромын католик шашинтай гэнэ.




# УЛС ТӨР

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ



## Н.Номтойбаяр сайд МҮЭХ-ны төлөөллүүдийг хүлээн авч уулзлаа

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр Монголынүйлдвэрчнийэвлэлийнхолбооныудирдлагаасбүрдсэн төлөөллийг өчигдөр хүлээн авч уулзлаа. Тавдугаар сарын 1-нд болсон МҮЭХ-ны тайван жагсаалд сайд Н.Номтойбаяр Засгийн газрыг төлөөлж оролцохдоо хэлэлцээрийн ширээнд урьсан нь энэ уулзалт юм. МҮЭХ-ны төлөөллүүд гурван сарын өмнө баталсан хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрт тусгасан зорилт, заалтууд хэрэгжилтийн тухай саналаа хэлсэн. Мөн тэтгэврийн нас, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн талаар байр сууриа илэрхийллээ.

Холбооны Ерөнхийлөгч Х.Амгаланбаатар "Бид хэлэлцээрийг эргэн авч үзэх бүрэн боломж байна гэж үзэж байна. Татварын асуудлаар бид бүгдийг нь эсэргүүцээгүй. 4-5 татварыг манай зүгээс дэмжиж байгаа. Ялангуяа тамхи болон согтууруулах ундааны онцгой албан татвар" хэмээж байв. Сайд Н.Номтойбаяр та бүхний тавьж буй саналуудыг Засгийн газар хүлээн авч, шийдвэрлэх бүрэн боломжтой. Үүний тулд та бүхний хамтын ажиллагаа чухал гэдгийг тодотгосон юм. Түүнчлэн энэ сарын 12-нд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн асуудлаар хэлэлцүүлэг болно. Уг хэлэлцүүлэгт МҮЭХ-ны төлөөлөл байх зайлшгүй шаардлагатай тул оролцохыг урьсан юм. Мөн 16-ны өдөр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын өргөтгөсөн хэлэлцүүлэгт ч МҮЭХ-ноос саналаа тусгаж, хамтран ажиллахыг хүслээ.

## МАХН-ын гишүүн 2000-2.5 сая төгрөгийн татвар төлнө

Н.ЗАЯА

МАХН-аас өчигдөр хэвлэлийн бага хурал хийлээ. Тус хэвлэлийн бага хуралд Налайх дүүрэг дэх МАХН-ын гишүүдийн Мянгатын дарга Н.Баяраа, МАХН-ын гүйцэтгэх товчооны гишүүн С.Ононбаяр, Хан-Уул дүүрэг дэх МАХН-ын гишүүдийн Түмтийн дэд дарга Г.Нямдаржаа, Баянзүрх дүүргийн Түмтийн дэд дарга Ч.Чинбаяр нар оролцов. Энэ үеэр Баянзүрх дүүрэг дэх МАХН-ын гишүүдийн Түмтийн дэд дарга Ч.Чинбаяр "МАХН-аас аравт болон зуутын гишүүдээ бэхжүүлэх зорилгоор татвар, хандивын талаар нээлттэй мэдээлэл хийж байна. Манай намын гишүүд сар бүр 2000, аравтын дарга 10 мянга, зуутын дарга 20 мянга, мянгатын дарга 200 мянга, түмтийн дарга 300 мянган төгрөгийн татварыг намдаа өгөх ёстой.

Харин бага чуулганы гишүүн 200-300 мянга, хяналт ёсзүйн хорооны дарга 100 мянга, хяналт ёсзүйн хорооны гишүүн 50 мянга, намын нарийн бичгийн дарга 100-300 мянга, дэд дарга нэг сая төгрөг, намын дарга 2.5 сая төгрөгийн татварыг намдаа өгдөг. Тиймээс бид намынхаа нийт гишүүдэд хандан татвараа төлөхийг уриалж байна" гэв. Намынхаа нийт гишүүдэд татвараа төлөхийг уриалж буй уриалах энэхүү үйл ажиллагааг Налайх дүүргийн МАХН-ын залуучууд зохион байгуулж байгаа аж. Мөн хэвлэлийн хурлын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдийг хэрхэн сонгох, намын бага чуулганы тов гарсан эсэхийг лавлан асуувал хэвлэлийн бага хурлын зорилготой холбогдолгүй гэх шалтгаанаар тодорхой хариулт өгөөгүй юм. Харин "Манай намын бага чуулганы гишүүд нийслэлд ирсэн. Бид хэзээ бол хэзээ намынхаа бага чуулганыг хийхэд бэлэн" гэв.

БАЙР СУУРЬ

## Э.БАТ-ҮҮЛ: ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙГ БОЙКОТЛОЁ

Улаанбаатар хотын захирагч асан Э.Бат-Үүл өчигдөр сэтгүүлчдэд хандаж, мэдээлэл хийсэн билээ. Мэдээллийнхээ эхэнд тэрбээр гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой луйврын асуудлаар ярьсан. Харин дараа нь Ерөнхийлөгчийн сонгуульд яагаад өрсөлдөөгүй талаараа мэдээлэл өгсөн юм.

### "МАН-ынхан дахин төлөвлөлтөөр луйвар хийх гэж байна"

Нийслэлийн Засаг дарга асан Э.Бат-Үүл дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаар "Би гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой асуудал, яаж луйвар хийж байгаа талаар мэдээлэл өгөх гэж ирсэн юм. Өчигдөр / өнгөрсөн мягмар гараг/ АН-ын байрны үүдэнд хэсэг иргэн цуглаж, гэр хорооллын дахин төлөвлөлтөөс болж хохирч байна хэмээн мэдэгдэж, улс төрийн үйл ажиллагаа явуулсныг та бүхэн мэдэж байгаа. Гэтэл дахин төлөвлөлттэй холбоотой жагсаалд үнэн хэрэг дээрээ төрийн албан хаагчид оролцсон. Тэр дундаа дахин төлөвлөлтийг хариуцах ёстой албан хаагчид оролцлоо. Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбож, намайг гүтгэн гүжирдэж байгаа зорилго нь бидний эхлүүлсэн ажлыг мушгиж, цаашлаад дахин төлөвлөлтөөр луйвар хийх гэж байна. Тэр луйврыг нь сайн мэдэж, илчлэх хүн нь би учраас над руу дайралт хийгээд байгаа юм. Бидэн рүү зориуд дайраад байна. Та бүхэн мэдэж байгаа, 2016 онд би ажлаа өгөхөөсөө өмнө гэр хорооллын дахин төлөвлөлтийн дуусаагүй барилгуудыг дуусгахаар 76.5 тэрбумыг зарцуулахаар төлөвлөөд, 40 тэрбумыг нь бэлэн болгосон. Нийслэлийн төсөвт 20 тэрбумыг суулгаад, арилжааны банкууд 20-ыг гаргаад, 10 хувиас дээш гүйцэтгэлтэй, гэр хорооллын дахин төлөвлөлтийн талбайд эхэлсэн барилгуудыг дуусгахаар шийдвэрлэсэн. 25 барилга барих ёстой байсан. Энэ 25 барилгыг барьж дуусгахад 3291 иргэн, тэр дундаа гэр хорооллын, газраа чөлөөлсөн 1200 өрх орон сууцанд орох ёстой байсан юм. 2016 оны намар нь орон сууцандаа орно шүү дээ. Гэтэл МАН сонгуульд ялаад, ажлаа авсныхаа дараа нийслэлийн төсөвт суулгасан байсан 20 тэрбум төгрөгийг байхгүй болгосон. Өөрөөр хэлбэл, 10-аас дээш хувийн гүйцэтгэлтэй орон сууцийг барих ажлыг зогсоосон гэсэн үг. Уг нь газраа чөлөөлсөн иргэд өнгөрсөн намар байрандаа орох ёстой байсан. Нэмээд 1800 орчим иргэн шинээр орон сууцтай болох байлаа. Гэр хорооллын дахин төлөвлөлтөөр баригдсан орон сууцанд орсон иргэдэд таван хувийн ипотекийн зээл өгөхөөр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, сайд С.Эрдэнэ нарын гарын үсэгтэй Засгийн газрын шийдвэр гарсан байсан. Сүүлдээ барилга барьдаг компани бүхэн дахин төлөвлөлтөд оролцох хүсэлтээ өгч эхэлсэн. Энэ ажлыг зогсоосон. Энэ ажлыг зогсоосны шалтгаан нь борлуулалтын хяналтыг нь өөрсдөө авах, бизнес хийх л байгаа юм. Гадныхаар хөрөнгө оруулалт хийлгээд, борлуулалтыг нь өөрсдөө авна. Мөн гэр хорооллын иргэдийн хашааны газрыг маш хямд үнээр авна. Ийм бусармаг ажил хийх гээд байна. Энэ үйл ажиллагаагаа нуун дарагдуулахын тулд намайг гүтгэн гүжирдэх үйл ажиллагааг эрчимтэй явуулж байна. Тийм болохоор би гэр хорооллын иргэдтэй нэг бүрчлэн уулзана. Энэ луйврыг илчилнэ" хэмээлээ.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

### "Иргэдийн саналыг худалдаж авах бүх бэлтгэл хангагдсан"

Дахин төлөвлөлттэй холбоотой асуудал ярьсны дараа тэрбээр Ерөнхийлөгчийн сонгуульд яагаад өрсөлдөхөө больж, дотоод сунгаанд оролцоогүй талаараа ярьсан юм. Э.Бат-Үүл "2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг бойкотлоё гэж Баабар бид хоёр уриалсан. Өнөөдөр сонгуулийг луйвардаж, санал худалдаж авах бэлтгэл аль хэдийнэ хангагдчихсан байна. Өөрөөр хэлбэл, хууль бусаар төрийн эрх мэдлийг авах бэлтгэл хангагдчихлаа. Та бүхэн мэдэж байгаа, АН-ын дарга С.Эрдэнэ гишүүдтэйгээ уулзах үедээ хэлсэн. "Өнгөрсөн жил 50 мянган хүн мөнгөөр саналаа худалдсан. Гэхдээ мөнгийг авч болно оо, саналаа өөрийнхөө итгэл үнэмшлээр өгөөрэй" гээд учирлаад сууж байна. Саяхан судалгаа хийгээд үзэхэд бага, дунд орлоготой иргэдийн 70 хувь нь мөнгөөр саналаа өгнө гэсэн. Тэгэхээр Үндсэн хуулийн бус аргаар санал худалдаж авдаг явдлыг таслан зогсоохгүй, энэ мэтээр өөхшүүлсээр байвал болохгүй ээ. Сая Үндсэн хуулийн өөрчлөлт нэрээр дарангуйллын тогтолцоог оруулж ирлээ шүү дээ. Өөрөөр хэлбэл, шууд босоо удирдлагатай. Ерөнхий сайд нь сумын Засаг даргыг хүртэл томилдог болох өөрчлөлтийг ярьж байна. Төр нь авлигад автчихсан энэ нийгэмд хэн нэгэнд эрх мэдлийг төвлөрүүлж өгвөл дарангуйллыг бий болгоно. Дарангуйлал би болгох саналаа Үндсэн хуулийн өөрчлөлтөөр оруулж ирж байна. Энэ эрх мэдлээ сонгогчдын саналыг худалдаж авах замаар олж авах нь. Гэтэл АН хууль бусаар төрийн эрх мэдлийг авахыг мэдсээр байж. Иргэдийн саналыг худалдаж авна гэдгийг мэдэж байж сонгуульд оролцоно гэдэг бол хамтрагч болж байна гэсэн үг. Тийм учраас сонгуульд оролцож болохгүй ээ. Улс төрийн бусад хүчнүүдтэй ярилцаад, бүх нийтийн бойкот хийх хэрэгтэй. Ард түмэнд сануулах цаг болсон. Би энэ асуудлыг намын даргадаа ч хэлсэн. Санал худалдаж авах байдал урьд өмнө нь байгаагүйгээр өргөн хэмжээнд явагдана. Та бүхэн саяхан МАН-ын дарга Монголын хамгийн том компанийн захирлуудтай суугаад "Бүрэн зураглал" гэдэг нэвтрүүлгээр ярилцлагад орж байгааг харсан байх. Тэд сонгуулийн дараа Ерөнхийлөгч болчихоод ингэнэ гэж яриад байгаа юм уу, хаашаа юм. Тухайлбал, АПУ компани гэхэд 124 тэрбум төгрөгийн татвар өгдөг. Бод доо та нар, ямар том хэтэвч вэ. МАН-ын дарга хууль зөрчиж байгаагаа авч хэлэлцэж байгаа ч юм алга. Шууд нулимж байна билээ. Өмнө нь сонгуулиар ийм зүйл болж байгаагүй. Тэр дундаа Монголын хамгийн том бизнесмэнүүд суучихаад, Ерөнхийлөгч болчихоод тэгээрэй гэх маягийн юм ярьж байсан түүх байхгүй. Сонгуульд өрсөлдөх гэж байгаа хүн нь өөрийнхөө хэтэвчийг ингэж зарлаж байсан удаа ч байхгүй. Харин энэ удаад ийм явдал боллоо. Би тийм учраас л намынхандаа уриалсан. Сонгуулийн дүн гарсны дараа УИХ МАН-ын нэр дэвшигчийг асуудалгүй батална. Хүмүүс Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай гэдгийг мэддэггүй юм. Эхлээд ард түмнээсээ, дараа нь УИХ-аар батлуулдаг, хоёр шаттай. Хэрвээ манай намын нэр дэвшигч ялаад гараад ирвэл наад 65 чинь хүлээж авахгүй. Баянзүрхэд болдог шиг л юм болно. Ийм ёс бус зүйл рүү орж болохгүй гэж намынхандаа сануулсан. Би өөрөө сонгуулийг бойкотлоё гэж уриалчихаад нэр дэвшинэ гэж юу байх вэ дээ. Ийм луйварт би оролцохгүй" хэмээн мэдэгдлээ.

БАГА ХУРАЛ

## ИТГЭЛ, ЯЛАЛТ, ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ЭВЛЭЖ ЗҮТГЭЦГЭЭЕ

*МАН-ын бага хуралд намын дарга, Монгол Улсын их хурлын дарга Миеэгомбын Энхболдын хэлсэн үгийг бүрэн эхээр нь хүргэж байна.*

**Намын Бага хурлын хүндэт гишүүд ээ, Эрхэм журмын анд нөхөд өө,**

**Юуны өмнө Та бүхэндээ чин сэтгэлийн угаас талархаж буйгаа илэрхийлье.**

Эх оронч, эрэлхэг зоригт өвөг дээдсийн минь үүсгэн байгуулсан Монгол Ардын Намынхаа дөрвөн намирах туганд, Монголын төлөө гэсэн нэгэн үзүүрт сэтгэлээр гар гараасаа барьж, зүтгэн тэмцэж яваа намынхаа мянга мянган гишүүдийн гэгээн өлмийд гүнээ хүндэтгэл үзүүлж байгааг минь хүлээн авна уу?

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд намайг дэвшүүлсэн энэ үйл явдлыг би АСАР ИХ ИТГЭЛ, ӨНДӨР ХАРИУЦЛАГА гэж гүнээ ухамсарлан, хүлээж авч байна. Сая энд сууж байхдаа үүрэг, даалгаврын асар том ачаа мөрөн дээр бууж ирэхийг ихээхэн тод мэдэрлээ. Би Монгол Ардын Нам хэмээх өндөр босготой, өлзийт голомттой их айлд, энэрэл түшгийн уул мэт өнөр бүлийн дунд өсөж торниж, өдий зэрэгт хүрсэн хүн. Төрийн байгууллагын жирийн албан хаагчаас Их хотын захирагч, Монгол Улсын Засгийн газрын тэргүүн, хууль тогтоох дээд байгууллага Парламентын спикер хүртэлх миний амьдралын 30 гаруй жилийн өгсүүр замын улаач, хөтөч нь та нар минь, Нам маань байсан. 96 жилийн бахархалт түүхтэй, улс үндэстнийхээ тусгаар тогтнол, сэргэн мандалт, хөгжил дэвшлийн манлайлах түүчээ, зүтгэх зүтгүүр нь болсоор ирсэн энэ том намыг удирдах хувь заяа надад хоёронтаа тохиолоо. Өөрт байгаа чадлын хэрээр, хоёргүй сэтгэлээр хичээн зүтгэсээр өнөөг хүрсэн.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Энэ хугацаанд хүрсэн үр дүн, амжилт ялалт бүхэн Та бидний хамтын бүтээл билээ. Наян нэгэн уньтай, наранд өргөсөн тоонотой монгол гэрийг ганц хүн барьж чадахгүй. Түүний нэгэн адил бид намынхаа энэ цаг үеийн түүхийг хамтдаа бүтээж явна аа. Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд намаа төлөөлөн нэр дэвших эрхийг Та бүхэн надад оноолоо.

Миний амьдрал, намтар түүхэнд бас нэгэн ховор гайхалтай үйл явдал ийнхүү тохиож байна. Өнөөдрийг хүртэл надад "Заавал Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ" гэсэн улайрсан бодол, хатуу зорилго байгаагүй, үнэнийг хэлье. Энэ сонгуульд Монгол Ардын Намаас нэр дэвших боломжтой хүмүүсийн нэг нь л би байсан байх. Сонгуулийн амаргүй сунгаанд шандас цуцахааргүй, барианд баараагүй түрүүлээд ирэх чансаатай улстөрчид манай намд цөөнгүй бий. Гэсэн ч тэдгээр хүмүүс болон намын хамт олон надад итгэл, батламжаа өвөртлүүллээ. Энэ шийдвэр нь ардаараа овоглосон намынхаа эгнээнд 30 шахам жил тууштай зүтгэсэн зүтгэл, төр засгийн өндөр нэр хүндтэй албуудыг цөөнгүй жил хашсан туршлага, яг энэ түүхэн үед намаа тэргүүлж байгааг минь хүндэтгэсэн хэрэг буй за хэмээн сүслэн хүлээж авч байна. Та нарынхаа энэ их хүндлэл, найдварыг хөсөрдүүлэхгүйн төлөө бүхий л боломжоо шавхан зүтгэх болно. Надтай хамт та нар минь бас намын мянга мянган гишүүд дэмжигчид байгаа болохоор халшрах зүйл байхгүй ээ. Та бүхэн надад итгэсэн шиг, Та нартаа би итгэж байна. Хамтын ялалт бидэнд ирнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Эрхэм нөхөд өө, Улс орон, ард иргэдийн маань амьдрал таарууxан байна. Хэн ийм болгосон, юу тиймд хүргэсэн талаар олныг ярьж, хойшоо харахыг би хүсэхгүй байна. Бид одоо зөвхөн урагшаа харах ёстой. Эрмэлзэл тэмүүллийн хүрэх цэг хол, эсвэл төвөгтэй байж болно. Гэхдээ өнөөдрийн итгэл үгүйгээр түүнд хүрч чадахгүй. Тиймээс иргэдийнхээ сэтгэлд итгэлийн гал асаах нь юу юунаас чухал байна. Бидэнд, надад хэрвээ буруу бий бол түүнээ засъя. Зөв бас байгаа бол түүнээ баталгаажуулъя.

Илүү олшруулж, өсгөн үржүүлье. Ингэж чадвал бидний ирээдүйн зам илүү тодорхой, шулуун дардан болно. Ийм итгэлийг иргэддээ бэлэглэхийн тулд том зорилго тавьж, түүндээ хүрэхийн төлөө зогсоо чөлөөгүй ажиллах цаг иржээ. Тиймийн тулд өнөөдрөөр биш, маргаашаар амьсгалцгаая. Монгол асар их баялагтай. Өргөн дэлгэр нутаг дэвсгэртэй. Цөөхөн хэрнээ гайхалтай оюунлиг, авьяаслаг ард түмэнтэй.

Монголыг хөгжлийн асар их ирээдүй хүлээж байна гэж гаднынхан хэлэлцдэг. Бид ч өөрсдөө ингэж ярьдаг. Тэгэхээр тэр ирээдүй рүүгээ Монголчууд нийтээрээ тэмүүлье. Бид нэг буурин дээрээ мэтгэлцэж, маргалдсаар хэтэрхий уджээ. Тиймээс одоо нэгдмэл байр суурьтайгаар урагшлан зүтгэх цаг болсон. Болохгүй бүтэхгүй, буруу хазгай бүхнээ буурин дээрээ орхиод урагшилцгаая. Энэ тэмүүлэл хөгжил дэвшил тийш, сайн сайхан амьдралыг зорих их нүүдэл байх болно гэдэгт эргэлзэхгүй байна. Монголчууд нэг зорилго, нэгдмэл эвтэй байсан цагтаа л хүчирхэг байсан. Энэ цаг үе биднээс зөвшилцөл ойлголцлыг, эв нэгдлийг, улс гэрийнхээ дотор үймж бужигнахгүй, тогтвортой тохинуун байхыг шаардаж байна. Ингэж чадвал бид ирээдүйн сайн сайханд түүртэх юмгүй хүрнэ. Би эрдэм ухааны далай өтгөс буурлууд, энэ үеийн түүхийг бүтээж яваа дунд үеийнхэн, ирээдүй маргаашийг дархлах бадрангуй залуусынхаа аль алинд бүрэн итгэж байна.

**Тиймээс ИТГЭЛ, ЯЛАЛТ, ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ЭВЛЭЖ ЗҮТГЭЦГЭЭЕ.**

*Монгол Улс минь мандан бадрах болтугай. Монгол Ардын Намын түүх шинэ ялалтын мөрүүдээр тэтгэгдэх болтугай.*

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

# ОРОН НУТАГ

Аймгаас мэдээлж байна

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

## “Бид бүжигчид”-Тийм ээ, та нар үнэхээр бүжигчид

Т.БОЛДБААТАР

“Бид бүжигчид”. Дэлхийн бүжигчдийн өдрийг угтаж, Говьсүмбэр аймгийн дуу бүжгийн Боржигин чуулгын бүжиг ангийн хамт олны хийсэн тоглолтын нэр. Тэд үнэхээр бүжигчид. Тийм ээ, та нар ясны бүжигчид, чухамдаа урлагийн үйл ажиллагааг шүүгчдийн хэлээр дотортой, ёстой заяаны бүжигчид. Суудалдаа тогтож чадахгүй өндөлзөх үзэгчдийн сэтгэлийн үнэлэлт, тайз, тааз холбон шаагих бахархал талархлын алга ташилт ийн хэлээд байлаа. Энэ ангийнхан 2010-2014 онуудад Монгол Улсын УГЗ, бижиг дэглээч Д.Санжаасүрэнгийн нэрэмжит зүүн бүсийн аймгуудын мэргэжлийн бүжигчдийн уралдаанд гоцлол бүжгийн төрөлд тэргүүн байр, хамтлаг бүжгийн төрлөөр дэд, гутгаар байр, Зууны манлай бүжиг дэглээч, ардын жүжигчин Ц.Сэвжидийн нэрэмжит мэргэжлийн бүжигчдийн улсын уралдаанд тэргүүн байр эзэлсэн амжилтын эзэд юм.



Таван хос бүжигчид, бүжгийн дугуйлангийн авьяаслаг сурагчид олон ястны, боржигин, сонгодог, орчин үеийн 10 дэглээчийн 17 бүжгийг чадварлаг бүжиглэв. Уран бүтээлийн тайлан тоглолтоо алдарт “Адуучин”-аар мэндчилэн нээсэн нь аз хийморь, цалгисан авьяасыг урьчихсан шиг урьсан ч байх. Дорноговь, Дорнодын театрыг бүжиг сайтай л гэлцэх. Манайхан юугаар дутах гэж. 20 гаруй өсвөрийн бүжигчид 66 шаазан аягыг хангир жингэр унагалгүй бүжих, гуурстай мэт хүлгийн нуруун дээр бүргэдчиний холч хараагаар цоо ширтэж домбор хөгжмөө баруун солгойгүй тоглох хасаг хүү... дор бүрнээ өөрийн хэл, дүрслэл, тоглолттой.

Циркийн хөдөлгөөн, түүхийг бүжгээр амилуулан сануулах уран биеийн галбираараа гайхуулан аугаа их амьдралыг тэр дундаа монгол ахуйг харуулан бүжиглэцгээсэн билээ. О.Цэрэнжаргалын дэглэлт “Богдын салхи”, З.Дашнямын дэглэлт “Өчил”, МУСТА Хосбаярын дэглэлт “Зүүдний хүлэг” бүжгүүд онцгой, онцгой. Төрийн шагналт, АЖ, зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн “Жалам хар”-ыг ярих юм биш. Монголчууд бүгдээрээ жалам хартай юм биш үү. Тоглолтод чуулгын уран бүтээлчид ая дуугаа өргөсөн нь нэгэн түрлэг болов. Энэ үеэр чуулгын уртын дууч Ш.Энхбаяр, бүжигчин З.Дашням, Г.Мөнхцэцэг нар Засгийн газрын шагнал Монгол Улсын СТА цол, тэмдгээр шагнагдсанаар бүжиг ангийнхан дөрвөн СТА-тай боллоо.

Шагнагдагсдыг төлөөлүүлэн шинэхэн МУСТА Зоригтын Дашнямтай уулзаж ярилцахад “Би Жалам харыг хүүхэд байхын л бүжиглэж эхэлсэн. УГЖ Алтангэрэл багшийнхаа урилгаар 2007 оноос Хөгжим бүжгийн коллежид суралцаж төгссөн. Бүжгийн багшаар чуулгадаа гурван жил ажилласан. “Жанжин Чойр” орчин үеийн бүжгийн хамтлаг маань 2014 оноос хойш жил бүрийн тэмцээнээс тэргүүн байрын шагнал авч ирлээ. Өнөөдөр салбарын дээд шагнал авч байгаадаа маш их баяртай байна. Хамт олондоо баярлалаа” гэсэн юм. Бүжиг ангийнхан бүгд шагнуулсан, хийж бүтээсэн улс аргагүй. Удаа дараагийн олон улсын тэмцээнээс тэргүүн, гранпри шагнал хүртсэн Алтан гадас одонт, МУСТА О.Цэрэнжаргал, бүжиг ангийн багш МУСТА Э.Алтанзул нарын мэргэжлийн ур чадвар, наалдацтай сургуулилтын чанар чансаа бүжиг ангийнхны уран бүтээлийн үр дүнд нөлөөлсөн байж таараа. Үнэндээ ч О.Цэрэнжаргалын брэнд эргэлтийн техник өвлөгдөн үлдэж байгаа юм байна. Тоглолт, эвсэл, ур чадвар шалгасан нарийн хөдөлгөөнүүдийг залуу бүжигчин үндэсний гэж хэлэхэд болох боловсон хүчин Б.Манал, З.Дашням нар чинээнд нь тултал гүйцэтгэж байгааг үзэгчид үнэлж байсан нь урлагийн мэдрэмж шат ахиж буйг харуулсан хэрэг. Хөтлөгч эмэгтэйн хэлснээр “Үзгээр бичээгүй бүхнийг үзүүлэнхэн бүжиглэлээ” Говьсүмбэр аймгийн Боржигин чуулгын бүжиг ангийн “Бид бүжигчид” тоглолтод оролцсон бүх бүжигчид.

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



# А.ИШДОРЖ: ЭЛСЭН ЖУУЛЧЛАЛЫН МЭДЭЭЛЛИЙН

Ч.ЧУЛУУН

*Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга Ишдоржтой манай сэтгүүлч уулзаж ярилцсан байна.*

...Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух тээвэр ложистикийн төв болох зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Өвөрхангай аймгаас Баянгол сум, Сайхан овоо, Дундговь аймгийн төвтэй холбогдох 320 км автозам тавих асуудлыг тусгасан. Хэрэвзээ зам тавигдчих юм бол Шивээ хүрэн, Гашуун сухайтаар орж ирэх жуулчид Өмнөговь, Дундговь, Өвөрхангай цаашлаад Хархориноор дайраад Архангай, Хөвсгөл чиглэлийн төвийн бүсийн босоо тэнхлэгтэй холбогдчихож байгаа юм...

**-Өвөрхангайчууд хөгжлийнхөө баримт бичгийг боловсруулахдаа ямар салбарт өндөр ач холбогдол өгсөн бэ. Хөгжлийн чиг хандлагыг ямар байдлаар тодорхойлов гэдгээс ярилцлагаа эхлэх үү?**

-Өвөрхангай бол 1992 оноос хойш улстөрийн хувьд харьцангуй тогтвортой байгаа аймаг. УИХ-ын сонгуулиудад МАН байнга, тогтвортойгоор ялалт байгуулж, амжилт үзүүлсээр ирсэн. Үүнийг яагаад онцолж байна вэ гэвэл орон нутаг тэр хэрээр хурдацтайгаар хөгжиж ирсэн гэсэн үг. Ер нь улс төрийн нөхцөл тогтворгүй байх нь орон нутаг гэлтгүй улс орны хөгжилд том чөдөр тушаа болдгийг бид маш сайн мэднэ. Харин бидэнд тийм асуудал тулгарч байсангүй. Тиймээс Өвөрхангай аймаг бодлогын баримт бичгээ дунд болон урт хугацаагаар боловсруулж, түүнийгээ дөрөв, дөрвөн жилээр нь үечилж өгсөн. Тухайлбал, 2015 онд Өвөрхангай аймаг 2015-2020 он хүртэлх хөгжлийн бодлогын баримт бичгээ боловсруулж, түүнийхээ дагуу хөгжиж байгаа. Чухам тэр үед ч тогтвортой хөгжлийн бодлогын үзэл баримтлалыг гол тулгуур болгож байлаа. Анхандаа мөрийн хөтөлбөр, хөгжлийн баримт бичгээ боловсруулахдаа нэн тэргүүнд эдийн засгийн өсөлт гэж ярьдаг байсан бол энэ удаад нэгдүгээрт, байгаль орчин дараа нь эдийн засаг, ажлын байрыг тавих жишээний. Байгаль орчинтой холбоотой асуудалд аялал жуулчлал багтдаг. Өвөрхангай аймагт аялал жуулчлал социалист нийгмийн үед ч хөгжиж ирснийг та бүхэн мэдэж буй. Аялал жуулчлалыг аймгийн хэмжээнд бүсчилж хөгжүүлэхээр 2016-2020 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж батлуулсан. Зүүн бүсийн аялал жуулчлал гэхэд Өндөр гэгээний өсч төрсөн нутаг, өндөр гэгээнийг ширээнд анх залсан их, бага Монгол уул, Ширээ цагаан нуур, Өвгөн суварга, хойшоогоо Өвгөн тарины хийд наашаагаа Хархорин, Төвхөн хийд багтана. Баруун чиглэлийн аялал жуулчлалын бүсэд Баруунбаян-Улааны элсний амралт сувилал, Богд сумын нутагт орших эртний үлэг гүрвэлийн олдворуудыг үзүүлэх юм. Богд сум өөрөө манай аймгийн хамгийн өндөр цэг. Их, бага Богд уул маань бий. Тэнд адал явдалт аялалыг зохион байгуулж болно. Ер нь говь өөрөө тэр чигээрээ жуулчдын очихыг хүсдэг газар шүү дээ. Мөн түүнчлэн Өмнөговь аймгийн Хонгорын элсийг хамруулсан маршрутыг бий болгож болно. Хойд чиглэл буюу хангай бүст Хархорин, Орхоны Улаан цутгалан, Бат-Өлзий, Найман нуур, Төвхөн хийдийг санал болгоно. Асуудал үүгээр дуусахгүй. Аялал жуулчлалын маршрутаа дагасан үйлчилгээний төвийг бий болгох ёстой. Жуулчдад зориулсан мэдээллийн төвийг Хархорин, Хашаатын заагт орших Элсэн тасархай хавьцаа байгуулъя гэж Архангайн удирдлагуудтай ярилцаж, санал солилцсон. Гадны улс орнуудад аялж байхад хурдны зам дагасан 100 км тутамд иж бүрэн зогсоол бүхий үйлчилгээний газрууд ажиллаж байдаг. Тийм хэмжээний цогцолборыг Элсэн тасархайд байгуулах юм. Манай хоёр аймаг төсвөө нийлүүлж асуудлыг шийднэ. Засгийн газарт хүсэлтээ тавьсан. Үүний үр дүнд жуулчид Элсэн тасархайд дахь мэдээллийн төвөөс хаашаа аялахаа сонгох учиртай. Манай Өвөрхангай чиглэлийн аялалыг сонгосон жуулчид дээр өгүүлсэн гурван бүсээс сонголтоо хийнэ. Хэдэн км-т хоноглох айл байх, хэдэн км яваад өдрийн хоолоо идэх гээд бүх мэдээлэл хадгалагдсан байна гэсэн үг. Ингэж аялалын маршрутыг тодорхой болгохгүй бол Өвөрхангай аймаг гэхээр ганцхан Эрдэнэзуу, Хужирт, Бат-Өлзий гэж ойлгодог. Бодлогын бичиг баримтад тусгагдсан бас нэг зүйл нь Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух тээвэр ложистикийн төв болох зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Өвөрхангай аймгаас Баянгол сум, Сайхан овоо, Дундговь аймгийн төвтэй холбогдох 320 км автозам тавих асуудлыг тусгасан. Хэрэвзээ зам тавигдчих юм бол Шивээ хүрэн, Гашуун сухайтаар орж ирэх жуулчид Өмнөговь, Дундговь, Өвөрхангай цаашлаад Хархориноор дайраад Архангай, Хөвсгөл чиглэлийн төвийн бүсийн босоо тэнхлэгтэй холбогдчихож байгаа юм. Ингэж чадах аваас тээвэр ложистикийн асуудалтай зэрэгцээд аялал жуулчлалын


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 05-р сарын 04
**Тендер шалгаруулалтын нэр:** “Багануур” ХК-ний 2016 онд хэрэглэх Сэлбэг материал нийлүүлэгчийг сонгох. Тендер шалгаруулалтын дугаар СШУ № БНХК-2017-СМ(01-02)-1

“Багануур” ХК эрх бүхий тендерт оролцогчдоос ЭКГ 8и Экскаваторын шанаганы шүд нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь Худалдаа Хөгжлийн банкны 499031495 тоот дансанд 50000 төгрөгөөр эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютыг тушаасан баримтаараа худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил

Тендерийн баталгаа нь санал болгож буй нийт үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй байна.

Тендерийг 2017 оны 06 сарын 05-ны өдрийн 14 цагаас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 сарын 05 /ны өдрийн 14 цаг 30 минутанд Багануур ХК-ийн захиргааны байранд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**

*Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр ажлын цагаар хаяг №1-ээс худалдан авах, тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг №2, №3-аас авч болно.*

*Хаяг №1: Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг. “Багануур” ХК-ний төлөвлөгчийн байр.Ахлах менежер П.Нямхүү Утас : 70157719, 99172076 Факс : 70157719*
*Хаяг №2: Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн дарга С.Батхишиг Утас 70210364*
*Хаяг №3: Багануур дүүрэг “Багануур”ХК-ын захиргааны байр. №306 тоот Техникийн бодлогын хэлтсийн инженер Х.Ганхүү Утас: 7021-0351, 99071029*

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 05-р сарын 04
**Тендер шалгаруулалтын нэр:** “Багануур” ХК-ний 2016 онд хэрэглэх. Сэлбэг материал нийлүүлэгчийг сонгох. Тендер шалгаруулалтын дугаар СШУ № БНХК-2017-СМ(01-01)-1

“Багануур” ХК эрх бүхий тендерт оролцогчдоос Төмөр бэлдэц нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь Худалдаа Хөгжлийн банкны 499031495 тоот дансанд 50000 төгрөгөөр эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютыг тушаасан баримтаараа худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил

Тендерийн баталгаа нь санал болгож буй нийт үнийн дүнгийн 2%-тай тэнцүү байна.

Тендерийг 2017 оны 06 сарын 05-ны өдрийн 15 цагаас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 сарын 05 /ны өдрийн 15 цаг 30 минутанд Багануур ХК-ийн захиргааны байранд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**

*Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр ажлын цагаар хаяг №1-ээс худалдан авах, тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг №2, №3-аас авч болно.*

*Хаяг №1: Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг. “Багануур” ХК-ний төлөвлөгчийн байр.Ахлах менежер П.Нямхүү Утас : 70157719, 99172076 Факс : 70157719*
*Хаяг №2: Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн дарга С.Батхишиг Утас 70210364*
*Хаяг №3: Багануур дүүрэг “Багануур”ХК-ын захиргааны байр. №306 тоот Техникийн бодлогын хэлтсийн инженер Х.Ганхүү Утас : 7021-0351, 99071029*

# ОРОН НУТАГ

# ТАСАРХАЙД АЯЛАЛ ТӨВ БАЙГУУЛНА

салбар өндөр түвшинд хөгжих боломж бүрдэх юм.

**-Маш таатай мэдээлэл байна. Харин ажил хэрэг болох нь хэдийнээс вэ?**

-Хөрөнгө санхүү бага шаардагдах ажлуудыг түрүүлж энэ хавартаа багтаж эхлүүлнэ. Хамгийн гол нь бүх зүйл хөрөнгө, санхүүтэй холбоотой асуудлаас болж гацдаг. Аймаг өөрийнхөө бололцоонд тулгуурлах хэдий ч улс орны эдийн засаг ямар байгаа билээ дээ.

**-Өвөрхангай татаас авдаг аймгуудын нэг. Уул нь та бүхэнд эдийн засгийн нөөц бололцоо бий. Малынхаа тоо толгойгоор улсад тэргүүлж, ашиглаж чадах аваас боломжийн хэмжээний эргэлтийн талбайтай санагдах юм?**

-Хархорин сум бол манай газар тариалангийн бүс нутаг. Одоогийн байдлаар 20 орчим мянган га эргэлтийн талбайтай. Талбайн хэмжээг нэмэгдүүлж болно. Харамсалтай нь, Орхоны хөндийн түүх соёлын дурсгалт газрууд хөндөгдчих гээд байдаг юм. Дэлхийн өвийн санд бүртгэгдсэн байдаг тул талбайн хэмжээг нэмэгдүүлэх нь боломжгүй асуудал. Бусад сумдад газар тариаланг хөгжүүлэх боломж байхгүй. Яагаад гэвэл мал ихтэй. Энэ жил гэхэд манай аймаг таван сая 208 мянган толгой мал тоолуулсан. Малын тоо толгой өсөх тусам бэлчээр хомсддог. Үүнээс болж тариаланч, малчин хоёр хоорондоо зөрчилдөж эхэлдэг. Хархорины тариаланчид малчдын эсэргүүцэлтэй байнга тулгардаг. Тийм учраас бид боловсруулах үйлдвэр барьж ашиглалтад оруулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Хүссэн хүсээгүй таван сая 208 мянган толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулахгүй бол бэлчээрийн даац хүрэлцэхгүй болно шүү дээ. Энэ л чухамдаа бидний тулгамдсан асуудал болоод байгаа. Мах боловсруулах хоёр үйлдвэрийг сонирхон судалж байна. БНХАУ-ын болон АНУ-ын хөрөнгө оруулалттай үйлдвэр. Аль аль нь нааштай хариу ирүүлсэн. Нөгөөтэйгүүр, өнөөдрийн байдлаар Өвөрхангай аймаг л малын гоц халдварт өвчингүй эрүүл бүс нутаг. Тэр утгаараа хөрөнгө оруулагчид манай аймагт махны үйлдвэр байгуулах сонирхолтой байгаа юм билээ. Тэгээд ч манайх төвийн бүс. Төвийн бүсийн аймгуудын малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, эцсийн бүтээгдэхүүн болгож чадах аймгийн төдийгүй мал бүхий иргэдийн амьдрал дээшилж, хөдөө аж ахуйн салбарын орлого нэмэгдэнэ. Зах зээлийн жам ёсоор аль нэг салбар нь өндийгөөд ирвэл бусад салбартаа сайнаар нөлөөлж таарна.

**-Эдийн засгийн эргэлтэд орж байгаа 20 мянган га талбайдаа төмс, хүнсний ногоо, улаанбуудайг зэрэгцүүлж тарьдаг уу?**

-Төмс, хүнсний ногоо, улаанбуудайгаас гадна рабс тариалдаг. Сүүлийн жилүүдэд тариаланчид өндөр үнэ, ажиллагаа бага шаарддаг гээд рабс тариалах сонирхолтой болсон байна билээ. Аймгийн зүгээс нийт талбайн 15 хүртэлх хувьд рабс тариалахыг зөвшөөрдөг. Рабс хөрсний хамаг шим шүүсийг сорчихдог гэмтэй ургамал. Өнгөрсөн жилээс 4-5 мянган орчим га талбайд чацаргана тариаллаа. Боломжийн ургасан. Тиймээс энэ жилдээ багтаж чацаргана боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн. Хэрэв үйлдвэр байгуулагдчихвал бүх суманд чацаргана тариална. Зах зээл нь ч байгаа.

**-Гурилын үйлдвэрийн талаар та дуугарсангүй. Зогсонги байдалтай байгаа юм байна гэж ойлголоо?**

-Хархорин сум гурил, тэжээлийн үйлдвэртэй. Үйлдвэрийн хүчин чадал маш бага. Аймгаа ч бүрэн хангаж чаддаггүй юм. Бараг л зогсонги талдаа.

**-Малчид ноолуураа хэдийнэ самнаад эхэлчихсэн. Ноолуур элбэгших хэрээр үнэ нь буусаар байгаа. Ноолуураас орж ирэх орлогыг орон нутагтаа шингээж үлдэх тухайд та бүхэн юу хийж байна вэ?**

-Сумдынхаа удирдлагуудтай яг энэ асуудлаар саяхан зөвлөлдөж, санал бодлоо солилцсон. Ноолуурын ханш өнөөдрийн байдлаар кг нь 46 ам.доллар байх шиг байна. Харамсалтай нь ченжүүд малчдын гар дээрээс 70 мянган төгрөгөөр авч байгаа. Энэ ханш өдрөөс өдөрт унах нь ойлгомжтой. Уг нь ноолуурыг угаагаад зах зээлд гаргавал кг нь 100 ам.доллар хүрнэ. Өвөрхангай ноос, ноолуур боловсруулах хоёр ч үйлдвэртэй. Зундаа 200 орчим хүн ажилладаг. Малчдаас кг ноосыг 700-800 төгрөгөөр худалдан авч угаагаад 4500 төгрөгөөр зах зээлд нийлүүлдэг. Ихэнхдээ экспортолдог. Мөн ноосон хөнжил, гудас, бүслэвч мэтийн ойр зуурын хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын зах зээлд гаргадаг. Ноосны үйлдвэрээ өргөтгөн ээрмэлийн үйлдвэр байгуулахаар зураг, төслийг нь гаргасан. Төсөл удахгүй хэрэгжинэ. Үүний үр дүнд ээрмэл утас бий болж, ноосон даавуун бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм. Ноос угаах төхөөрөмж нь бэлэн байна, үйлдвэрлэл нь ч бэлэн. Гагцхүү нэмүү өртгөө шингээх явдал. Тонн ноолуурыг угаахаар 50 орчим хувь нь хорогддог ч ашиг нь өндөр тусдаг. Жишээ нь 80 сая төгрөгөөр ноолуур худалдаж аваад таван саяар угаалгахад цаана нь 30 хэдэн сая төгрөгийн ашиг гарч байгаа юм. Нэмүү өртөг ийм л ашигтай. Багцаагаар бодож үзэхэд шүү дээ.

**-Та бид хоёр сумдын хөгжлийн талаар ярилцсангүй. Сум, орон нутгаа хөгжүүлэх тал дээр та бүхэн юу хийж байна вэ?**

-Сум болгон онцлогтой. Түгээмэл зүйл гэвэл орлогынх нь эх үүсвэр мал аж ахуй. Тиймээс мал аж ахуйгаа түшиглэн хөгжих ёстой. Энэ нь малын гаралтай түүхий эдээ сумандаа боловсруулан зах зээлд нийлүүлэх явдал. Өвөрхангай аймаг Франц улстай хамтран ажиллаад 15 жил болж буй. Хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн салбарын хөгжлийн асуудлыг тодорхой түвшинд шийдэж чадсан. Энэ жилээс хөдөө аж ахуйн салбарт хамтарч ажиллахаар болсон. Тухайлбал, хамтарсан бяслагны үйлдвэр байгуулна. Уянга суманд бяслагны жижиг цех бий. Монголд үйлдвэрлэсэн бяслагыг Щвейцар руу экспортлодог. Францчууд хонь, ямаа, үнээнийхээ сүүгээр 300 гаруй нэр төрлийн бяслаг хийдэг юм билээ. Гэтэл манай малчид өдөрт нэг удаа л сааль авдаг. Түүхий эдээ бүрэн боловсруулж чаддаггүй учраас тэр. Бяслаг өөрөө махан бүтээгдэхүүн биш учраас хилийн хорио цээр бага л гэж ойлгож байгаа. Сүүгээ халааж ариутгаад бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг учраас эрүүл ахуй талдаа асуудалгүй. Тиймээс бид монгол бяслагийг олон нэр төрлөөр хийж олон улсын болон дотоодын зах зээлд нийлүүлнэ. Мөн энэ жил таван суманд сүүний үйлдвэр оруулж ирнэ.

**-Мал сүргийн бүтэц гэж том асуудал бий. Магадгүй миний ажигласнаар малчид эдийн засгийн өгөөжийг нь бодоод ямааг түлхүү өсгөөд байх шиг. Ялангуяа говийн сумдын хувьд. Бэлчээрийн даац хэтэрч байгаа энэ үед ямаа өсгөх нь зөв шийдвэр мөн үү?**

-Та бидний байнга ярьдаг, хэлэлцдэг сэдвийг хөндлөө. Аймгийн удирдлагын зүгээс энэ дөрвөн жилд үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлнэ гэсэн байр суурьтай байгаа. Үхэр нийт мал сүргийн долоо орчим хувийг эзэлдэг бол ямаа 42 хувьтай байх жишээний. Хонь 44 хувьтай, үлдсэн нь адуу, тэмээ. Малчид эдийн засгийн үр ашгийг нь хараад ямаа өсгөөд байна л даа. Тиймээс ямаан тоо толгойг бодлогын хэмжээнд барьж байхгүй бол бэлчээрийн даац хэтрэх асуудал тулгарч мэднэ.

**-Та иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын хувьд Өвөрхангай аймгийн айл өрхийн амьжиргааны төвшин ямар байна. Өнгөрсөн жилтэй харьцуулахад өссөн үү. Ямар үзүүлэлтүүд буурав гэдгийг их л анхааралтай ажиглаж байгаа шүү дээ?**

-Өмнөх жилтэй харьцуулахад, бага зэрэг өссөн. Иргэдийн амьдралын түвшин дээшилсэн эсвэл буурсан эсэхийг иргэдийн мөнгөн хадгаламжаас мэдэж болдог. Манай банкуудад нийтдээ 150 орчим тэрбум төгрөгийн хадгаламж эргэлдэж буй.

**-Уянга суманд уул уурхайн хичнээн компани үйл ажиллагаагаа явуулж байгаа вэ. Тэд орон нутгийн хөгжилд нөлөө үзүүлж чадаж байна уу?**

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компани бараг байхгүй. Уянгын бүлэг ордын нөөц бараг шавхагдсан. Үлдэгдэл дээр нь орон нутгийн иргэд ажиллаж, гар аргаар олборлодог. Нөхөн сэргээлтийн тухайд сүүлийн үед нэг зовлонтой зүйл гарч ирээд байгаа. Засгийн газрын 308 тогтоолын хүрээнд нутгийн иргэд илэрц багатай, ашиглах боломжгүй газарт нөхөрлөл байгуулж, гар аргаар олборлолт явуулах эрхтэй болсон. Бид үүнийг буруу бодлого гэж үзэж байгаа. Хувь хүн, нөхөрлөлийн аль нь ч хэзээ ч ухсан талбайгаа нөхөн сэргээж байгаагүй, чадах ч үгүй. Аймагт ямар ч мэдэл байхгүй. Сум шийдээд явдаг болсон. Нөхөрлөлийнхөн дээгүүр явж хөөцөлдөж байгаад Байгаль орчин, Уул уурхайн яамтай гэрээ байгуулдаг. Үнэндээ цөөн тооны хэдхэн хүн л өдрийн хоолоо залгах гэж гар аргаар олборлодог бол хөрөнгөжсөн, техникжсэн иргэд нинжа нэрийн дор хууль бусаар алт олборлож байгаа шүү дээ. Тэднээс орон нутагт нэмэр тус болно гэж горьдож суух хэрэггүй. Харин ч гэмт хэрэг өдүүлж, нэгнийхээ амийг үрчих вий гэхээс эмээж суудаг.

**-Ер нь хэчнээн лиценз олгогдсон байдаг юм бол?**

-Нэлээн хэд, 20 орчим компани ашиглалтын болон олборлолтын лиценз эзэмшдэг. Ихэнх нь нэг, зарим нь хоёр лицензтэй. Тэдний үйл ажиллагаа харилцан адилгүй л дээ.

**-Нөхөн сэргээлтийн тухайд ямар бодлого барьж байна вэ?**

-Эрх мэдэлгүй аймаг юу хийж чадах юм. Ашигт малтмалтай холбоотой бүхий л асуудлыг сум өөрөө шийддэг болсон. Нинжа нарын сүйтгэсэн талбайг нөхөн сэргээнэ гэдэг үнэхээр хэцүү асуудал. Бид нар нинжа гэдгийг ядарсан, өдрийн хоолоо залгуулах гэж буй иргэд гэж ойлгодог байсан. Нэг хэсэг нь тийм байсан. Гэтэл одоо хөрөнгөжсөн, техникжсэн хүмүүс нинжа нэрийн дор хууль бусаар алт олборлодог болсон. Эдүгэ биднийг Орхон голын асуудал зовоож байна. Эхэл ухлыг нь хөөгөөд үзэхээр Архангай аймгийн Тамирын голд гар аргаар алт олборлож байгаа иргэдийн хууль бус үйл ажиллагаа Орхон голыг сүйтгэж байгаа нь тогтоогдсон. Өөр аймгийн асуудлыг бид яалтай. Аймгийнх нь удирдлагуудад албан тоот хүргүүлээд л суущгааж байна.









Төв аймгийн Батсүмбэр сумын 324 дүгээр зогсоолын Үдлэг багт байрлалтай 100 үнээний багтаамжтай, өөрийн гүний худаг, 380v цахилгааны эх үүсвэр болон усалгааны системийн хажууд байрлах 7800м2 газартай, 14.2м өргөн, 47м урттай блокоор барьж, тоосгоор өнгөлсөн 64-ийн ханатай, орчин үеийн шийдэлтэй үнээний ферм зарна.

**Үнэ: 200.0 саяас**
**Холбогдох утас: 99057278**


## Аймгаас мэдээлж байна

ДАРХАН-УУЛ АЙМАГ

### Дарханы ЗДТГ угтах үйлчилгээг нэвтрүүллээ

Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, тэгш хүртээмжтэй, хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх, хэлтэс албадын уялдаа холбоо, төр иргэний хамтын ажиллагааг сайруулах зорилгоор Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар угтах үйлчилгээг нэвтрүүлжээ. Угтагч ажлын өдрүүдэд өглөөний 08:00-17:00 цаг хүртэл иргэдэд үйлчилж, тэдний санал хүсэлтийн хүлээн авч, зөвлөмж зөвлөгөө өгөхөөс гадна тулгарсан асуудлыг холбогдох албан тушаалтанд уламжилж, газар дээр нь шийдвэрлүүлэх боломж бүрдэж байгаа юм байна. Түүнчлэн, төрийн үйлчилгээ иргэдэд ойртож, нээлттэй, шуурхай байдал дээшлэх давуу талтай аж. Иргэдийн хүсэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг үзүүлснээр иргэдийн сэтгэл ханамж дээшлэх ач холбогдолтой гэдгийг албаныхан онцолжээ.

ДОРНОГОВЬ АЙМАГ

### 10 өрх өргөө цагаан гэртэй боллоо




“Их бүтээн байгуулалтын жил-2017” шав тавих нээлтийн ёслолын үйл ажиллагаа боллоо. Энэ үеэр “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд айл өрхүүдийн амьжиргааг дээшлүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Дорноговь их хөгжлийн сан” ТББ-ын санхүүжилтээр амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой зорилтот бүлгийн 10 өрхөд буюу Сайншанд сумын иргэн С.Мишигсүрэн, Е.Нарантуул, З.Энхмаа, О.Гэрэлмаа, Б.Анхбаяр, Б.Энхцэцэг, О.Гэрэлт-Од, Ж.Ням-Эрдэнэ, М.Болормаа, Б.Нарантуяа нарт өргөө цагаан гэрийг гардуулан өглөө.

### “Дорноговь-бага олимп” энэ сарын 17-20-ны өдрүүдэд болно

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, биеийн тамир, спортоор хичээллэх, ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Дорноговь-бага олимп”-ийг энэ сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгуулах гэж байна. Бага олимп сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, үндэсний бөх, аэробик, хөнгөн атлетик, шатар, даам, олс таталт зэрэг спортын есөн төрлөөр явагдана. Дорноговь аймагт оршин суугаа насанд хүрсэн бүх иргэд оролцох боломжтой тул иргэд та бүхэн идэвхтэй оролцохыг аймгийн ЗДТГ-аас уриалж байна.

### Даамын тэмцээнээс зургаан медаль хүртлээ



Узбекистан улсын Ташкент хотноо болсон Ази тивийн аварга шалгаруулах даамын тэмцээнд Дорноговь аймгийн харьяат, Монгол Улсын аварга даамчин Б.Мөнх-Эрдэнэ нэг алт, хоёр мөнгө, Азийн хүрэл медальт, Монгол Улсын даамын хос мөнгө, хүрэл медальт Г.Шинэсаран хоёр алт, нэг хүрэл, О.Тэмүүлэн мөнгөн медаль хүртсэн байна. УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин болон холбогдох албаны хүмүүс хүлээн авч, аймгийн Засаг даргын “Жуух бичиг” болон Нутгийн зөвлөлийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулжээ.

ОРХОН АЙМАГ

### Архивчид маань “Архивч-2017” уралдааны шилдгээр тодорлоо

Монгол Улсад орчин цагийн Архивын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ой энэ онд тохиож байна. Үүний хүрээнд төвийн бүсийн төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудын дунд “Архивч-2017” уралдаан амжилттай явагдаж дүнгээ гаргалаа. Үүнд Орхон, Дархан Уул, Сэлэнгэ, Төв аймгийн болон “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн архив, албан хэрэг хөтлөлтийн 150 гаруй ажилтан оролцсон байна. Тэд спортын зургаа, урлагийн болон ур чадварын тус бүр дөрвөн төрөлд өрсөлдөж дүнгээ гаргахад багийн дүнгээр Орхон аймгийн ЗДТГ-ын Архивын тасаг тэргүүн байр эзэллээ. Тодруулбал, АЗДТГ-ын Архивын тасгийн хамт олон спортын төрөлд буюу гар бөмбөгийн тэмцээнд алтан медаль, сагсан бөмбөгийн эрэгтэй багийн төрөлд мөнгөн медаль, теннисийн эрэгтэй, эмэгтэй төрөлд тус тус алтан медаль хүртжээ. Мөн бүжиг, хөгжмийн төрөл тус бүрт шилдэг нь байж тэргүүн байр эзэлсэн байна. Түүнээс гадна ур чадварын төрөлд Монгол бичгийн мэдлэгээр хоёрдугаар байр, Мэдээлэл технологийн төрөлд гуравдугаар байрт шалгарснаар багийн дүнгээр тэргүүлжээ.

NO STRESS

Оддын ЦАГ

# Аделийн тухай таны мэддэггүй 9 ÁÀÐÈ Ì Ò



Б.СУМЬЯА

Дэлхийн хамгийн алдартай дуучдын нэг болох Аделийн тухай таны мэдэхгүй ч байж магадгүй есөн баримтыг энэ удаагийн “Оддын цаг” буландаа сонирхуулахаар бэлдлээ.



**1. Тэр алдартнуудтай нэг ангид сурч байжээ**

Адель “БРИТ” сургуульд урлаг, технологийн чиглэлээр суралцсан. Ингэхдээ маш олон алдартнуудтай нэг танхимд сурч байжээ. Тэдний нэг нь Эми Вайнхаус байв. Бас Жесси Жей, Леона Льюс нартай нэг ангид сурч байсан гэнэ. Жесси Жей нэг удаа “Капитал ФМ”-д өгсөн ярилцлагадаа “Надад маш олон төрлийн найз бий. Би Адельтай нэг жил хамт сурсан. Өдрийн хоолны цагаар хамтдаа ярилцаж, дуулж, шүлэг бичдэг байлаа” гэж ярьжээ.

**2. Аделийн “Hello” түүх бүтээсэн**

“Hello” дуунд ямар ч онцгой зүйл байхгүй. Зүгээр л удтал урлагаас завсарласан Аделийн эргэн ирж буй уран бүтээлийн л нэг хэсэг болж байсан юм. Гэвч, энэ дуу хөгжмийн ертөнцөд нэгэн түүх бүтээсэн. Тэр нь клипний зургийг дэлхийн хамгийн өндөр нарийвчлал бүхий “I max” камераар авсан явдал юм. Энэ камерыг Оскарын шагнал хүртсэн шилдэг кинонуудад ашиглаж байжээ. Тухайлбал, “Interstellar”, “Hunger Games5 Catching Fire”, “Оддын дайн-хүч сэргэсэн нь” зэрэг кинонд ашигласан гэнэ.

**3. Анхны дуугаа 16 настайдаа бичүүлж байв**

Залуу насандаа нэр алдарт хүрсэн түүний эрч хүчинд, авьяас чадварт нууц гэж байхгүй. Адель цомгоо хэдэн насандаа гаргана, түүгээрээ нэрлэдэг. Тухайлбал, “19” цомгоо 19 настайдаа гаргаж байсан бол “21”, “25” цомгоо ч мөн 21, 25 насандаа гаргасан юм. Тэгвэл анхны дуугаа дуучин бүсгүй 16 насандаа бичүүлж байв. Түүний хамгийн анх бичсэн дуу нь “Hometown Glory” бөгөөд тухайн үед өөрийн “My space” хуудастаа байршуулжээ. Улмаар 2008 онд дахин бичүүлсэн байна.

**4.Адель Гиннесийн маш олон амжилтын эзэн**

Энэ магадгүй Аделийг амжилтад хүрэхийн тулд ямар олон саад бэрхшээлийг туулсан гэдгийг мэддэг шүтэн бишрэгчдийнх нь хувьд гайхмаар мэдээ биш байх. Түүний “Hello” дууны клип “Youtube” хуудаст хамгийн хурдан хугацаанд тэрбум хандалт авч чадсан байдаг. “hello” тус сайтад нийтлэгдсэнээс хойш 88 өдрийн дотор л тэрбум хандалт авч, PSY-ын “Ганнам стайл” дууны амжилтыг эвдсэн билээ. “Ганнам стайл” 159 өдөрт тэрбум хандалт авч байсан юм. Үүгээр зогсохгүй хоёр сингл, хоёр цомог нь хэдэн долоо хоног дараалан шилдэг тавд багтсан Их Британийн хамгийн анхны эмэгтэй дуучин болжээ.

**5. Түүнд нууц шивээс бий**

Аделийн зарим шүтэн бишрэгчид нь түүнийг онцгой шивээстэй гэдгийг тэр бүр мэддэггүй гэнэ. Тэгвэл түүний чихний ард “А” үсгийг шивсэн байдаг. Энэ нь түүний бяцхан хүү Анжелогийн нэрний эхний үсэг аж. Тэрбээр мөн гартаа “Paradise” гэх шивээстэй бөгөөд үүнийгээ Нью Йоркт хийлгэж байжээ.

**6. Мэс засал хийлгэснийхээ дараа зургаан долоо хоног сураг алдарч байв**

Адель хоолойны мэс засал хийлгэсний улмаас АНУ-д хийх хоёр ч удаагийн аялан тоглолтоо цуцалж байжээ. Харин хоолойгоо эргэн хэвийн байдалд орох хүртэл зургаан долоо хоногийн турш интернэт орчноос сураг тасарсан гэдэг. Гагцхүү тэрбээр дахин дуулахын тулд мэдрэгчтэй компьютер гэх мэт бүхий л зүйлсээс сэжиглэдэг байжээ. “Би мэс засал хийлгэсэн учраас их сэжигч болсон байсан. Хэрэв би ангинатай болчихвол дуулж чадахгүй. Тиймээс компьютерын дэлгэцэнд хүрэх миний хувьд хар дарсан зүүд шиг л санагдаж байлаа” гэж Ванити фэйрт ярьжээ.

**7. “Spice girls” бол түүний шүтээн**

1990-ээд оны үед дэлхий нийтийг байлдан дагуулж явсан Их Британийн “Spice girls” хамтлаг одоо ч олон олон авьяастныг урлагийн ертөнц рүү хөтөлсөөр байгаа. Тэгвэл тус хамтлаг Адельд ч гэсэн нөлөөлжээ. Тэрбээр “Намайг ингэж хэлэхээр хүмүүс ихэвчлэн тоглож байна л гэж боддог. Гэхдээ намайг долоон настай байхад “Спайс гирлс” жинхэнэ тэсрэлт хийж байлаа. Тэднийг тайзнаа гарч ирэхийг хараад яг тэдэн шиг болохыг хүсдэг байсан. Үнэхээр тэдгээр эмэгтэйчүүдийн эрч хүч миний амьдралын нэгэн том хэсэг байсан” гэж ярьж байв.

**8. Тэр шагналуудаа угаалгын өрөөндөө хадгалдаг**

Хөгжмийн ертөнцийн олон ч томоохон наадмуудаас шагнал хүртэж байсан авьяаслаг уран бүтээлч тэрбээр шагналуудаа ер нь хаана хадгалдаг юм бол. Энэ тун ч сонирхолтой. Адель Оскарын шагналаа унтлагынхаа өрөөнд, харин бусдыг нь угаалгын өрөөндөө хадгалдаг гэнэ. Тэрбээр “Sun” сэтгүүлд “Би бие засахаар ОО-ын өрөө рүүгээ орох бүртээ авсан шагналуудаа хардаг. Тэгээд “Гайхалтай, Сайн байлаа. Энэ жинхэнэ” гэж дандаа боддог” гэж ярьж байжээ.

**9. Түүний согтуудаа бичсэн жиргээг хянадаг**

Зарим олны танил хүмүүс өөрсдийнх нь өмнөөс твиттерт жиргэдэг хүнтэй байхад зарим нь ямар ч шүүлтүүргүйгээр өөрсдөө жиргэх нь бий. Тэгвэл Адельд өөрийнх нь твиттер сүлжээн дэх жиргээг нь хянах цөөн тооны хүн хэрэгтэй болсон гэнэ. Тэрбээр “Би согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг хүн биш л дээ. Гэхдээ твиттер сүлжээ дөнгөж нэвтэрч байхад согтуудаа элий балай зүйл биччихдэг байсан. Тэгээд манай менежментын баг хоёр хүн хөлсөлж, миний бүх жиргээг хянуулдаг болсон” хэмээн “Би Би Си”-д ярьж байжээ.

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр 10
Шөнө -8



Нөгөөдөр

Өдөр 18
Шөнө -1

## Өдрийн зурхай

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 05.30-20.08

**Үс засуулбал:** Өвчин өчүүхэн ирнэ



*Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээх, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.*

## Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд



**Б.Амаржаргал**

Таксинд суусан чинь хэлгүй дүлий бололтой залуу бал цаас гаргаад өгөхөөр нь хаана хүрэхээ биччихээд түгжрэлд зогсож байтал утас нь дуугараад, "Байна уу, юу байна андхан минь" гээд яриад эхэлдий. Сүмбээ заяаныхаа юуны зүүн гаранд хүрээд л хараа оруулдаг шиг би бал цаасаар нь дамжуулаад сонсгол бэлэглчихвүү яав. :р Тэгээд болоогүй ээ буух болсон чинь гарсан km бас бичээд өгч байна лээ.

ДУУЛГАХ СОНИН

## “АДИДАС ГУТАЛТАЙ ЭМЭГТЭЙН ОЛДВОР”-ИЙГ ОЛОН НИЙТЭД ДЭЛГЭЛЭЭ

Монгол Алтайн нурууны бүс нутаг буюу Ховд аймгийн Мянгад сумын нутаг Урд улаан үнээт уулаас 2015 онд Монголын Үндэсний музейн судлаачид, Мөнххайрхан сумын нутаг Үзүүр гялан хэмээх газраас 2016 онд Ховд их сургуулийн судлаачид тус тус илрүүлэн судалж буй хоёр хадны оршуулгаас гарсан хосгүй үнэт түүхэн олдворуудаар гаргасан “Хадан гэрийн соёл” үзэсгэлэн өчигдөр нээгдлээ. Үзэсгэлэнд Урд улаан үнээт уулын дурсгалаас нэхий дээл, доргоны арьсан дах, арьсан өмдтэй эрэгтэй хүний хатмал шарил, эмээл хазаар, хутга, нум сум, саадаг, хоромсого, арьсан ууттай модон тоглоом, адууны зүлд зэрэг урьд өмнө олдож байгаагүй олон сонирхолтой олдворуудыг үзүүлж байна. Харин Үзүүр гялангийн дурсгалаас дэлхий нийтэд “Adidas” хэмээн алдаршаад байгаа гутал, олон төрлийн малгай, дээл хувцастай, эмэгтэй хүний хатмал шарил, хазаар, хударга, хөмөлдөргөтэй бүрэн эмээл бүхий бүтэн морь бусад олон тооны ховор үнэт олдворуудыг дэлгэжээ.



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

